

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГО, ТҮҮНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН**

**ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА
БОДЛОГУУД НЬ ОНОВЧТОЙ ХЭДИЙ Ч ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ
МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ НӨӨЦ ДУТМАГ, ХАРИЛЦАН
УЯЛДААТАЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА**

АУДИТЫН КОД: : ХӨА-2024/20-21-ШТА-ГА

**Хөвсгөл аймаг
2024 он**

Дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням
Утас: 92113932 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Л.Мандахнаран
Утас: 92118277 Цахим хаяг: mandakhnaranl@audit.gov.mn

Аудитор: Н.Гүрбазар
Утас: 92118084 Цахим хаяг: gurbazarn@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. https://audit.mn/?page_id=579

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар

Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй

А. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГУУД НЬ ОНОВЧТОЙ ХЭДИЙ Ч ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ НӨӨЦ ДУТМАГ, ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээнүүд хоорондоо уялдаж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжийг бүрдүүлсэн байна

1.2. Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батлаагүйгээс орон нутагт хүний нөөцийн хүртээмж дутмаг, харилцан уялдаатай ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

Б. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ, ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН ШАЛТГААНЫГ БУУРУУЛАХ БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ТӨСВИЙГ ХАРАА ХЯНАЛТГҮЙ ЗАРЦУУЛЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛСАН БАЙНА.

2.1. Хүүхэд хамгааллын зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй, сумдад хүүхэд хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал хуваарилаагүй байгаагаас хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна

2.2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах төсвийг оновчтой хуваарилаагүй, үр ашиггүй нийт 148,878.5 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг хараа хяналтгүй зарцуулсан байна.

В. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БАТЛАГДААГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

3.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж байгаа хууль, журам, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-үнэлгээ хийх аргачлал батлагдаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдсан, үр дүнг тооцох боломжгүй байна.

3.2. Цахим, гэр бүл, сурч боловсрох орчны хүчирхийллээс хүүхдийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх сургалт сурталчилгааг хангалттай зохион байгуулаагүй зэргээс харахад хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

3.3. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн гэр бүлийн орчны хүчирхийллийг арилгах үйлчилгээ байхгүй нь хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үед дахин хохирогч болох эрсдэл байсаар байна.

Дүгнэлт:

Зөвлөмж:

Холбогдох байгууллагын санал:

Товчилсон үгийн жагсаалт:

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУГ	Боловсрол Шинжлэх Ухааны Газар
БШУЯ	Боловсрол Шинжлэх Ухааны Яам
ГНАГ	Гүйцэтгэл-Нийцлийн Аудитын Газар
ЕБС	Ерөнхий Боловсролын Сургууль
ХГБХХГ	Хүүхэд, Гэр Бүлийн Хөгжил, Хамгааллын Газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
СӨБ	Сургуулийн Өмнөх Боловсрол
ХГБХХГ	Хүүхэд Гэр Бүлийн Хөгжил Хамгааллын Газар
УИХ	Улсын Их Хурал



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар А/37

Мөрөн сум

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 29 дүгээр зүйлийн 29.4, Монгол Улсын Ерөнхий аудиторовн 2023 оны А/102 дугаар “Эрх үүрэг шилжүүлэх тухай” тушаалын 4 дүгээр хавсралтын 1.4 дахь заалт, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримтаж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн актыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, Хөвсгөл аймгийн засаг дарга, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газарт тус тус хүргүүлсүгэй.
4. “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримтаж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж үр дүнг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /П.Лхагважав/, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга Ч.Дашбаяр, Боловсрол шинжлэх ухааны газрын дарга О.Бадраа, Биеийн тамир спортын газрын дарга Б.Очирбат нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор /Б.Давааням/-д үүрэг болгосугай.
6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер /Б.Тэгшдэлгэр/-д даалгасугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудиторов 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн А/37 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



“Хүүхэд хамгааллын төлөөр төрөөс баримтаж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

№	Төлбөрийн акт, албан шаардлагын дугаар	Зөрчлийн утга
1	93/A2260439-ХӨА-2024/20-21-ШТА-ГА	Төлбөр барагдуулах тухай
2	95/ A2260439-ХӨА-2024/20-21-ШТА-ГА	Зөрчил арилгах тухай

--oo0oo--

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бүрэлдэхүүн

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6.3.3, 7 дугаар зүйлийн 7.1.2, 7.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд, Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/162 дугаар тушаал, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэсэн.

Аудитын зорилт

Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон бий болсон үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго оршино.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, төлөвлөлтийн тогтолцоо оновчтой эсэх;
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөлт, төсөвлөлт үр өгөөжтэй, хүүхдэд ээлтэй байж чадсан эсэх;
- Хүүхэд хамгааллын талаар баримталж буй бодлогын хэрэгжилт үр дүнтэй эсэх.

Аудитын хамрах хүрээ

Аудитад Хүүхэд хамгааллын тухай хуулийн хүрээнд хүүхэд хамгааллын чиглэлээр, үйл ажиллагаанд оролцдог төрийн болон төрийн бус байгууллагууд, Хөвсгөл аймгийн хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хуль зүйн хороо, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Цагдаагийн газар, Эрүүл мэндийн газар, Боловсрол шинжлэх ухааны газар, Соёлын газар, Биеийн тамир спортын газар, Мөрөн сумын 15 хамтарсан баг, Ерөнхий боловсролын Эрдмийн далай цогцолбор сургууль, Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, Политехникийн коллеж, дотуур байр, Улаан-Уул, Цагааннуур, Ренчинлхүмбэ сумын ЕБС, дотуур байрны орчин нөхцөл, хамтарсан багуудын 2019-2024 оны үйл ажиллагаа, баримт, мэдээллийг хамруулсан.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-6:2020 “Нийцлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, MNS 6817-8:2020 “Нийцлийн аудитын стандарт”, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, судалгаа явуулах, ярилцлага хийх арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг боловсруулсан.

Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүйтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан.

- Хүүхдийн Эрхийн Тухай Конвенц;
- Монгол Улсын Үндсэн хууль;
- Хүүхэд хамгааллын тухай хууль;
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль;

- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Боловсролын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр;
- Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл
- Хөвсгөл аймгийн ИТХ хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг 2016- 2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр.
- Аймгийн Засаг даргын 2016-2020, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Аудит хийсэн бүрэлдэхүүн

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Давааням, аудитор Л.Мандахнаран, Н.Гүрбазар нар гүйцэтгэсэн.


Үндсэн мэдээлэл

Хүүхэд хамгааллын тухай хууль нь анх 2016 онд батлагдсанаас хойш 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орж, 50 орчим журам, 8 стандартыг мөрдөж ажиллаж байна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2023 онд батлагдсан бөгөөд 2024 оны 9 дүгээр сарын 1-ны өдрөөс эхлэн хэрэгжиж эхэлсэн байна. Шинэчилсэн найруулгыг өмнөх хуультай харьцуулахад 24 зүйлийг шинээр нэмсэн бөгөөд хүүхэд хамгааллын талаарх үйл ажиллагаа, холбогдох талуудын үүрэг хариуцлагыг тодорхой болгож өгсөн зэрэг шинэчлэл найруулгыг хийсэн байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүүхэд хамгаалал” гэж нийгмийн бүх орчинд хүүхэдтэй зүй бус харьцах, хүүхдийг хүчирхийлэл, мөлжлөгт өртөхөөс хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн энэ хуульд заасан зарчмыг баримталсан цогц бодлого, үйл ажиллагаа, үйлчилгээг хэлнэ гэж заасан. Харин “хүүхэд хамгааллын үйлчилгээ” гэж хүүхэд хамгааллын тогтолцооны оролцогч талуудаас хүүхдийн хамгаалуулах эрхийг хангах зорилгоор үзүүлж байгаа шуурхай тусламжийн, хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээг хэлнэ” гэж тус заасан байна.

Хүүхэд хамгааллын талаар НҮБ-ын хүүхдийн эрхийн конвенц, Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор баталсан Хүүхэд хамгааллын чиглэлээр баримтлах бодлого, чиглэл, Засгийн газрын 2002 оны 245 дугаар тогтоолоор баталсан “Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр”-т тус тус тусган хэрэгжүүлж байна.

Зураглал №-1



Хөвсгөл аймагт 2023 оны байдлаар нийт 136,885 хүн амтай үүнээс 40,182 өрх, 49,831 хүүхэдтэй байна. Нийт хүн амын 36.4 хувийг хүүхэд эзэлж байна.

Нийт хүн амын 31.3 хувь нь аймгийн төв Мөрөн суманд, 19.1 хувь нь сумын төвд, 49.8 хувь нь хөдөө амьдарч байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд эрсдэлт нөхцөлд байгаа нийт 1,523 хүүхэд бүртгэлтэй байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газар, Хүүхдийн төлөө Зөвлөл 24 суманд 295 хүний бүрэлдэхүүнтэй, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 14 хүний бүрэлдэхүүнтэй, 38 хамтарсан баг 301 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Мөн төрийн байгууллагууд чиг үүргийн хувьд хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР



Шуурхай тусламжийн үйлчилгээний талаар: Хүүхдийн тусламжийн 108 утас болон бусад мэдээллийн сувгаар 2024 оны байдлаар нийт 1,586 дуудлага ирсэн байна. Үүнээс 1,442 дуудлага мэдээллийг хаасан, 144 дуудлага мэдээлэл дээр ажиллаж байна.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний талаар

Хүснэгт № 1

Он	нээсэн кейс	хаасан кейс	Нөхцөл байдлын үнэлгээ
2019 он	169	98	169
2020 он	210	172	210
2021 он	148	95	316
2022 он	197	161	236
2023 он	217	116	91
Дүн	941	642	1,022

2019-2023 онд нийт 941 кейс нээж 642 кейсийг хаасан бөгөөд эрсдэлт хүүхдийн 1,022 нөхцөл байдлын үнэлгээг хийж ажилласан байна.

Хамтарсан багуудын хүүхэд хамгааллын чиглэлээр 2019-2023 онд хэрэгжүүлсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээний тоон мэдээлэл. Хүснэгт № 2

Он	Урьдчилан сэргийлэх								
	Анхдагч					Хоёрдогч		ХХЭА-ыг сурталчлах, түгээх дэлгэрүүлэх чиглэлээр зохион байгуулсан сургалт	
	Зохион байгуулсан сургалт		Сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ		Илрүүлэлт, судалгаанд хамрагдсан гэр бүлийн тоо	Эрсдэлтэй гэр бүлийг илрүүлсэн, таслан зогсоосон үйлчилгээнд хамрагдсан гэр бүлийн тоо	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн тоо		
	тоо	хамрагдсан иргэд	тоо	Хамрагдсан иргэдийн тоо					
2019	215	46,342	170	18,294	300		3	190	30,152
2020	1	12	56	4,401	330		5	75	6,380
2021	71	251	214	926,959	2,690	125	9	39	1,516
2022	73	4,527	94	4,692	1,313	457	64	169	7,365
2023	23	3,164	30	3,396	93	35	22	26	2,609

Гэрээсээ дайжсан, үл хайхрах хараа хяналт сул хүүхдийг гэр бүлд нэгтгэсэн байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Хүснэгт №3

Огноо	Нэг цэгийн үйлчилгээний төвөөс үйлчилгээ авсан хүүхдийн тоо /үл хайхрах, хараа хяналт сул/	Гэр бүлд нь эргэн нэгтгэсэн хэлбэр	
		Гэр бүл	Хамтарсан баг
2019	35	6	29
2020	93	32	61
2021	96	32	64
2022	142	35	107
2023	136	36	100
Дүн	502	141	361

Гэр бүлээсээ дайжсан нийт 502 хүүхдээс 361 хүүхдийг хамтарсан багаар дамжуулан гэр бүлд нь буцаан нэгтгэсэн байгаа нь хамтарсан багийн үйл ажиллагаа чухал байгаа нь харагдаж байна.

А. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР ТӨРӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА БОДЛОГУУД НЬ ОНОВЧТОЙ ХЭДИЙ Ч ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСОН ХҮЧНИЙ НӨӨЦ ДУТМАГ, ХАРИЛЦАН УЯЛДААТАЙ АЖИЛЛАХ НӨХЦӨЛ БҮРДЭЭГҮЙ БАЙНА.

1.1. Улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээнүүд хоорондоо уялдаж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

1.1.1. Монгол Улс “Хүүхдийн эрхийн тухай конвенц”-ийг 1990 оны 07 дугаар сарын 05-ны өдөр соёрхон баталснаар 0-18 нас хүртэлх хүүхдийн эрхийг хуулиар хамгаалах чиг үүрэг хүлээсэн бөгөөд анх 1996 онд Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж хүүхэд хамгааллын талаарх эрх зүйн орчин бүрдэж эхэлсэн байна.

Орон нутгийн тухайд хүүхэд хамгааллын чиглэлээр урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт тодорхой зорилт арга хэмжээнүүдийг тусгаж баталсан байна. Хүүхэд хамгааллын эрх зүйн орчин болон хөтөлбөр, арга хэмжээнүүдийн тоон мэдээллийг схемээр харуулбал дараах байдалтай байна.

Схем № 1



Схемээс харахад Монгол улсыг хөгжүүлэх Алсын хараа 2050 хөтөлбөрт хүүхэд хамгааллын талаар тусгасан арга хэмжээнд нийцүүлэн Хөвсгөл аймгийн ИТХ хуралдааны 2015 оны 02

дугаар тогтоолоор баталсан Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг 2016- 2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрт нийт 5 зорилт, 53 арга хэмжээг тусгасан байна.

Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөрт тусгасан хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх арга хэмжээнд нийцүүлэн “Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 6 зорилт, 24 арга хэмжээ, 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт 12 зорилт, 38 арга хэмжээг тус тус тусгаж баталсан байна.

Аудитаар орон нутагт хэрэгжиж буй урт, дунд хугацааны бодлогын баримт бичгийн зорилтыг түүвэрлэн үзэхэд дараах байдалтай байна. Үүнд: *Хүснэгт № 4*

№	Хөвсгөл аймгийн нийгэм эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр	Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	Үр дүн
1	Хүүхэд, эмэгтэйчүүдийг “Хамгаалах байр”-ыг аймагт бий болгох	Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартад нийцүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид чиглэсэн мэргэжлийн цогц үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	2022 онд Нэг цэгийн үйлчилгээний төвийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 70.0 сая төгрөгөөр өргөтгөл хийсэн.
2	Сум бүрд хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын асуудал хариуцсан нийгмийн ажилтныг орон тоогоор ажиллуулж, хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулна.	Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг сумдад үе шаттай байгуулж хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан, мэргэжлийн сэтгэл зүйчдийг ажиллуулах замаар гэр бүлийн гишүүдэд чиглэсэн нийгэм, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг сайжруулна.	Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар 2025 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн сум бүрд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн орон тоогоор ажиллахаар болсон.
3	Аймаг, сумын Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхдийн хөгжил хамгааллын асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах	Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороодын үйл ажиллагааг тогтмолжуулж, хүүхдийн эрхийг хангах салбар дундын бодлого зохицуулалт, хамтын ажиллагааг сайжруулж, хүүхэд хамгааллын орон нутгийн тогтолцоог бэхжүүлнэ.	Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд ажил хэрэгч 4 захирамж, 2 албан даалгавар гарсан байна. Хөвсгөл аймгийн 24 суманд хүүхдийн төлөө зөвлөл байгуулагдан ажиллаж байна.
4	Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад хүүхэд төвтэй гэр бүл, олон нийт, төр, хувийн хэвшлийн харилцаа, түншлэлийг хөгжүүлэх	Орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудад эцэг, эхийн зөвлөл ажиллуулж, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг мөрдүүлэх, хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	2023 оны жилийн эцсийн байдлаар 206 байгууллага дэргэдээ эцэг эхийн зөвлөлийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгтээс харахад урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлэх зорилт арга хэмжээ харилцан уялдаа холбоотой байна.

Хууль тогтоомжийн талаар: Хүүхдийн эрх, хамгаалалд дараах хууль тогтоомжууд мөрдөгдөж байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль
- Гэр бүлийн тухай хууль болон бусад салбар эрх зүйн хууль тогтоомжууд мөрдөгдөж байна.

Хүүхдийн эсрэг үйлдсэн хүчирхийлэл тэр дундаа нэг цэгийн үйлчилгээнээс аюулгүй байдлын хамгаалалт авсан хүүхдийн нөхцөл байдлыг судлан үзэхэд тус хүчирхийллийн дийлэнх нь ахуйн хүрээний архидалттай холбоотой байна.

Хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл, үл хайхрах хүчирхийллийн дийлэнх хувийг архины хамааралтай эцэг, эх эзэлж байгаа боловч архины хамааралтай эцэг, эхийг албадан эмчлэх, түүний хүүхдийг хамгаалах талаарх эрх зүйн харилцааг уялдаатай зохицуулаагүй байна.

Тухайлбал: Архины хамааралтай иргэдийг албадан эмчилгээнд хамруулах ажлыг Мөрөн сумын Засаг даргын 2023 оны А/111 захирамжаар ажлын хэсэг байгуулагдан нэр бүхий 23 иргэний бүртгэл судалгааг гарган эрх бүхий байгууллагад хандсан хэдий ч Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3¹ дахь заалтад зааснаар тухайн иргэдийг хамруулах боломжгүй болсон байна. Мөн согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1²-д архи, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг саатуулах дээд хугацаа 24 цаг байхаар тогтоосон байгааг гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн эсэхээс хамааруулан ялгамжтай байдлаар тогтоох хэрэгцээ шаардлага тулгарч байна.

Согтууруулах ундаа хэрэглээгүй боловч хүүхдийн эсрэг аливаа хүчирхийлэл үйлдсэн этгээдийг Хүүхэд хамгааллын тухай хууль зөрчсөн гэж үзэн баривчлах эрх зүйн үндэслэлийг Зөрчлийн тухай хуульд тусгаж эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Зөрчлийн тухай хууль, Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн этгээдийг албадан эрүүлжүүлэх тухай хууль тогтоомжуудад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл үйлдсэн этгээдийг саатуулах талаар ялгамжтай тусгаагүйгээс анхан шатанд Хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, хамгаалах эрх зүйн бүрдээгүйгээс архи, согтууруулах ундаа хэрэглэж мансуурч буй гэр бүлийн орчинд амьдарч байгаа хүүхдийн эрх зөрчигдсөөр байна.

1.1.2. Хүүхэд хамгааллын талаар Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор “Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”, аймгийн ИТХ-ын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр”, “Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т дараах үндсэн зорилтыг тусгасан байна.

Хүснэгт № 5

№	“Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр”	Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр	Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр
1	Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангаж хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлнэ.	Хүүхэд, эмэгтэйчүүдийг “Хамгаалах байр”-ыг аймагт бий болгох	Нэг цэгийн үйлчилгээний төвийг стандартад нийцүүлж, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид чиглэсэн мэргэжлийн цогц үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
2	Нийгмийн бүх орчинд хүүхэд бүрийг үл хайхрах байдал, дарамт, хүчирхийлэл, мөлжлөгийн бүх хэлбэр, эрсдэлт нөхцөлд өртөхөөс хамгаална.	Хүүхдийн эрх ашгийг хамгаалахад хүүхэд төвтэй гэр бүл, олон нийт, төр, хувийн хэвшлийн харилцаа, түншлэлийг хөгжүүлэх	Орон нутгийн төр, хувийн хэвшлийн байгууллагуудад эцэг, эхийн зөвлөл ажиллуулж, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийг мөрдүүлэх, хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангахад иргэн бүрийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.

Дээрх хөтөлбөрүүдэд тусгасан зорилтын хүрээнд хөтөлбөр хүлээн авагчдын онцлогт нийцүүлэн дараах арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлсэн байна. Үүнд:

¹ “... гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, мөн насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, 16 нас хүрээгүй хүүхэд, 60-аас дээш настай хүн болон биеийн хүнд эмгэгтэй хүнийг албадан эмчлэхийг хориглоно.”

² Үйлчлүүлэгч этгээдэд эрүүлжүүлэх эмнэлгийн үйлчилгээ үзүүлж, эрүүлжүүлэх байранд 24 цаг хүртэл хугацаагаар байлгаж болно.

- 0-5 хүртэлх насны хүүхдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөц нэмэгдүүлэх;
- Сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, сургуульд бэлтгэх;
- Дэлгэцийн донтолт, архи, тамхи, мансууруулах бодисын хор нөлөө, хүчирхийлэл, дарамт, шахалт, эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар хүүхэд, өсвөр үеийнхэнд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах;
- Хүүхдийг насны онцлогт нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоотойгоор зохион байгуулах;
- хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй, бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэн хөгжүүлэх цогц бодлого хэрэгжүүлэх;
- хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг суурь боловсролд тэгш хамруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх зэрэг арга хэмжээг тусгасан байна.

Зохион байгуулсан арга хэмжээг түүвэрлэн үзэхэд дараах үр дүнд хүрсэн байна. Тухайлбал.

Хүснэгт № 6

№	Арга хэмжээ	2022 он	2023 он
1	0-5 хүртэлх насны хүүхдэд нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж үйлчилгээний нөөц нэмэгдүүлэх:	Аймгийн ЭМГ-ын даргын 2021 оны А/22 “Эх хүүхдийн эрүүл мэндийн сайжруулах талаар хэрэгжүүлэх ажлын чиглэл” - 18, 36 сар 5 хүртэлх насны 8098 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.	Аймгийн ЭМГ-ын даргын 2023 оны А/03 “Эх хүүхдийн эрүүл мэндийн сайжруулах төлөвлөгөө” -0-5 насны хүүхдийн гэрийн эргэлтийн 7-14 хоногт хийж, отор нүүдлээр шилжилт хөдөлгөөн хийсэн 0-5 настай хүүхдийг хяналтад авсан.
2	Сургуулийн өмнөх насны бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд бүрэн хамруулж, сургуульд бэлтгэх:	Аймгийн хэмжээнд 2-5 насны 8124 хүүхэд байгаагаас 2022 онд 7974 хүүхдийг хамруулсан байна.	Аймгийн хэмжээнд 2-5 насны 8241 хүүхэд байгаагаас 2023 онд 8031 хүүхдийг хамруулсан байна.
3	Хүүхдийг насны онцлогт нь тохируулан асрах, хүмүүжүүлэх мэдлэг, хандлагыг эцэг, эх, асран хамгаалагч нарт төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах:	Аймгийн хэмжээнд 21 удаагийн сургалтаар 14450 эцэг, эх асран хамгаалагчийг сургалтад хамруулсан.	Аймгийн хэмжээнд 179 удаагийн сургалтаар 21210 эцэг, эх асран хамгаалагчийг сургалтад хамруулсан.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүд нь хүүхэд, эмэгтэйчүүд,гэр бүлд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас харахад тус хөтөлбөрийн үр дүнг хүлээн авагчид нийгмийн бүх бүлэгт хамааралтай байна.

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд нь хүүхэд, эмэгтэйчүүд,гэр бүл гэх мэт нийгмийн бүх бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас харахад улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээнүүд хоорондоо уялдаж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.

1.2. Сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батлаагүйгээс орон нутагт хүний нөөцийн хүртээмж дутмаг, харилцан уялдаатай ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

1.2.1. Орон нутагт хүүхэд хамгааллын чиглэлээр холбогдох хууль тогтоомж, журамд заасан чиг үүргийг аймгийн Хүүхэд гэр бүл хөгжлийн газар хэрэгжүүлж байгаа ба чиг үүргийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.Үүнд:

Хүснэгт № 7

№	Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан чиг үүрэг	Хэрэгжилт
1	18.2.1.нутаг дэвсгэрийн хэмжээнд хүүхэд хамгааллын талаарх мэдээлэл, судалгаанд нэгдсэн дүгнэлт хийж, цаашид хийх ажлын чиглэлийг тодорхойлох;	Хэрэгжсэн.
2	18.2.2.төрийн байгууллага, хуулийн этгээд, шүүх, прокурор, хууль сахиулах байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх,	Хэрэгжээгүй.
3	18.2.3.Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх;	Хэрэгжээгүй.
4	18.2.4.нийгмийн ажилтан, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хороо, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэгчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;	Хэрэгжсэн.
5	18.2.5.эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн талаарх мэдээллийн сан бүрдүүлж үйл ажиллагаандаа ашиглах, бүртгэл, статистикийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн халамж, хамгаалал үйлчилгээний талаар бүртгэл хөтөлж, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;	Хэрэгжсэн.
6	18.2.6. эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хүүхэд харагчийг сайн дурын болон хуульд заасны дагуу шүүхийн шийдвэрээр албадан сургалтад хамруулах ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагатай хамтран зохион байгуулах;	Хэрэгжсэн.
7	18.2.7.гэр бүлээсээ дайжсан, эсхүл эцэг, эх, асран хамгаалагчийн халамж анхаарал, хараа хяналтаас гадуур байгаа хүүхдийг бүртгэх, судалгаанд авах, гэр бүлд нэгтгэх ажлыг орон нутгийн Цагдаагийн байгууллагатай хамтран гүйцэтгэх.	Хэрэгжсэн.

Хүснэгтээс харахад аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар нь хууль тогтоомжоор хүлээсэн 7 чиг үүргээс дараах 2 чиг үүргээ хэрэгжүүлээгүй ба хэрэгжилт 71.2 хувьтай байна. Үүнд:

- Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх
- Шүүх, прокурорын байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан албан хаагчийг сургах мэргэшүүлэх зэрэг ажлыг зохион байгуулаагүй байна.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлээгүй шалтгаан нь тус газрын Хүүхдийн эрх, хамгааллын асуудал хариуцсан мэргэжилтэн болон Хүүхдийн хөгжил, хамгааллын ахлах мэргэжилтний орон тоо сул байгаа, анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал батлагдаагүй, албан хаагчийг сургах мэргэшүүлэх зэрэг ажлыг санаачлан зохион байгуулаагүй зэрэгтэй холбоотой байна.

1.2.2. Дэлхийн бусад орны туршлагаас харахад Хүүхэд хамгааллын мэдээллийн удирдлагын систем нь **вэб** дээр суурилсан кейс менежментийн систем болон мэдээллийн сангаас бүрдэх бөгөөд мэдээлэл хадгалах, боловсруулах, хүүхэд хамгааллын хяналт, үнэлгээг хийх замаар эрсдэлд байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлэн, кэйс менежментийг үр дүнтэй удирдах зорилготой байна.

Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар нь дараах байдлаар мэдээллийн санг бүрдүүлэн ажиллаж байна. Үүнд: Хүснэгт № 8

№	Ашиглагдаж байгаа цахим систем	Зорилго	Мэдээллийн агуулга	Үр дүн
1	Able” систем   Хүүхэд, гэр бүл Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сан	“Хүүхэд гэр бүлийн мэдээллийн сан”	- Уралдаанч хүүхдийн бүртгэл - Эрсдэлийн үнэлгээ	Уралдаанч 200 хүүхдийн мэдээлэл, Эрсдэлт нөхцөлд байгаа 1523 хүүхдийн мэдээлэл
2	108.mn 	Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн талаарх мэдээллийг шуурхай авах	- Дуудлага өгсөн мэдээлэгч - Дуудлага өгсөн хэлбэр	Тус системд 2024 оны байдлаар нийт 1,586 дуудлага ирсэн байна. Үүнээс 1,442 дуудлага мэдээллийг шийдвэрлэсэн
3	www.etuslamj.mn 	Нэг цэгийн үйлчилгээний төвөөр (аюулгүй байдлын хамгаалалт) үйлчлүүлсэн хүүхдийн мэдээллийг бүртгэх и-тусламж системийг (www.etuslamj.mn) нэвтрүүлж байгаа хэдий ч шинэчилж байгаа тул мэдээлэлтэй танилцах боломжгүй байв.		

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь дээрх мэдээллийн системд хандах эрхтэй бөгөөд хандах эрх бүхий албан хаагчид холбогдох мэдээллийг баяжуулан ажиллаж байна. Тус системд оруулсан мэдээллүүд нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.13³-т заасны дагуу мэдээллийг гадагш задруулахгүй байх үүрэг хүлээсэн тул тус мэдээллийг иргэд олон нийтэд ил тод байх боломжгүй байна.

Хүүхэд хамгааллын салбар бүрийн мэдээлэл тус тусдаа нэгтгэгдэж нэгдсэн мэдээллийн сан бүрдээгүй ба цаашид хүүхэд хамгааллын бүх түвшний оролцогч талууд хандахад нээлттэй, бусад салбарын мэдээллийн нэгдсэн системтэй мэдээлэл солилцох, ашиглах, бүртгэлтэй мэдээлэлд дүн шинжилгээ хийх боломжтой байдлаар хөгжүүлэлт хийх шаардлагатай байна.

1.2.3. Хүүхэд хамгааллын тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 36 дугаар зүйлийн 36.6. “Тухайн нэгжийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батална” заасан боловч тус аргачлалыг Засгийн газраас хараахан боловсруулж, батлаагүй байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй хүний нөөцийн бүрэлдэхүүнийг авч үзвэл орон тооны, мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллага, орон тооны бус оролцогч талуудаас бүрдсэн байна. Үүнд:



³ мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг хадгалах;


Хүүхэд хамгааллын чиглэлээр мэргэжлийн албан хаагчидтай байгууллага нь аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын газар бөгөөд тус газрын хүүхэд хамгааллын чиглэлээр ажиллаж байгаа бүтэц орон тоог 2019-2024 онуудад дараах байдлаар тогтоосон байна. *Хүснэгт № 9*

№	Аймгийн Засаг даргын 2018 оны А/449	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2022 оны А37	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын даргын 2024.08.28-ны өдрийн А/194
1	Гэр бүл, хүүхдийн хөгжил хамгааллын нэгж-1	Хүүхдийн хөгжил, хамгаалал хариуцсан ахлах мэргэжилтэн – 1	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга - 1
2	Мэргэжилтэн - 4	Хүүхдийн эрх, хамгаалал хариуцсан мэргэжилтэн – 1	Хүүхдийн эрхийн улсын байцаагч – 1
3		Хүүхдийн эрхийн улсын байцаагч – 1	Эрсдэлт нөхцөл дэх хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн – 1
4			Кэйс менежмент хариуцсан мэргэжилтэн – 1

Дээрх хүснэгтээс харахад тус газрын бүтэц орон тоо хэд хэд өөрчлөгдсөн боловч хүүхэд хамгааллын мэргэжилтний чиг үүргийг агуулгын хувьд өөрчилсөн боловч тооны хувьд өөрчлөлт гараагүй байна. Хөвсгөл аймгийн хэмжээнд байгаа нийт 49,831 хүүхдэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх, хүүхэд хамгааллын хууль тогтоомж, дүрэм, журам, төрийн бодлогыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэхэд 1 мэргэжилтэнд 10,000 гаруй хүүхэд ногдож байна.

Хүүхдэд хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх сэтгэл засалчийн орон тоог тус газрын тоонд тусгаагүй байна. Энэ нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн сэтгэл заслын үйлчилгээ шаардлагатай хүүхдүүд орон нутагт тус үйлчилгээг авч чадахгүй Улаанбаатар хотод очиж сэтгэл заслын үйлчилгээ авахад цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн асуудал тулгардаг байна.

Хүүхэд хамгаалалд оролцогч талуудын хүний нөөцийг схемээр харуулбал дараах байдалтай байна.



Хүүхэд хамгааллын дээрх бүтцээс харахад 600 гаруй албан хаагч байгаа харагдаж байгаа боловч тус албан хаагчид нь хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэжлийн албан хаагчид биш бөгөөд салбар салбарын албан хаагчдаас бүрдсэн байна.

Анхан шатанд буюу хамтарсан багийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт № 10

Албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүрэг	Сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга	Аймаг төвийн сумын Хамтарсан багийн нарийн бичгийн дарга
	Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, хүн ам, гэр бүл, хүүхэд залуучууд, жендерийн тэгш байдлын талаарх хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилт	Хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх

Хүснэгтээс харахад Хөвсгөл аймгийн 23 сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга нь албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн индексийн дагуу ажиллаж байгаа боловч дийлэнх нь хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэжил эзэмшээгүй байна.

Сумдад ажиллаж байгаа нийгмийн бодлогын мэргэжилтний албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжил, тогтвор суурьшилтай ажилласан байдлыг хянахад:

- Албан тушаалын тодорхойлолтод заасан мэргэжлийн индексэд нийцэхгүй 7 албан хаагч байна. /Хавсралт-1-ээс харах/
- Тогтвор суурьшилтай ажиллаж байгаа байдлыг авч үзэхэд 1-2 жил ажилласан албан хаагч 37 хувийг эзэлж байна.

Дээрх тоо үзүүлэлтээс харахад сум бүрд хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжлийн албан хаагч орон тоогоор ажиллаж хэрэгцээ шаардлага үүссэн байгаа харуулж байгаа бөгөөд Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсэгт зааснаар 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сум, хороонд хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтныг ажиллуулахаар УИХ-аас хуульчлан баталсан нь чухал алхам болсон байна.

Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батлаагүйгээс орон нутагт хүний нөөцийн хүртээмж дутмаг, харилцан уялдаатай ажиллах нөхцөл бүрдээгүй байна.

Б. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТӨСВИЙГ ХҮҮХДИЙГ ЭРСДЭЛЭЭС ХАМГААЛАХ, ГЭМТ ХЭРЭГ ЗӨРЧЛИЙН ШАЛТГААНЫГ БУУРУУЛАХ БОДИТ АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙГ ТӨЛӨВЛӨӨГҮЙ, ТӨСВИЙГ ХАРАА ХЯНАЛТГҮЙ ЗАРЦУУЛЖ ТӨСВИЙН ҮР АШГИЙГ БУУРУУЛСАН БАЙНА.

2.1. Хүүхэд хамгааллын зардлыг бодит тооцоо судалгаанд үндэслэж төлөвлөөгүй, сумдад хүүхэд хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал хуваарилаагүй байгаагаас хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүн хангалтгүй байна.

2.1.1. Хүүхэд хамгааллын зардлын төсвийг дараах эх үүсвэрээс бүрдүүлэхээр Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 52 дугаар зүйлд тусгасан байна.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН САНХҮҮЖИЛТ



Хүүхэд хамгааллын санхүүжилтийг төлөвлөхдөө өмнөх онд шийдвэрлэсэн хүүхэд хамгааллын кейсийн тоо, үйлчилгээний чанар, үр дүнд үндэслэн дараа онд олгох санхүүжилтийг тогтооно.

Засгийн газрын гишүүн бүр эрхлэх асуудлын хүрээнд салбарын хүүхэд хамгааллын үйлчилгээ, хүүхэд хамгааллын чиглэлээр хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгуулах

Нутгийн өөрөө удирдах байгууллага хүүхэд хамгааллын санхүүжилт, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны ажил, үйлчилгээний зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгайлан тусгаж батална.

Хуулийн этгээд нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг жил бүр хүүхэд хамгааллын бодлого, Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхдэд ээлтэй, таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулахад зарцуулна.

Төсвийн төлөвлөлтийн талаар: Хүүхэд хамгааллын зардлыг 2019-2023 онд нийт 446,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж 606,300.0 мянган төгрөгийн төсвийг баталж улсын төсвөөс санхүүжүүлсэн бөгөөд орон нутгийн төсвөөс нэг цэгийн үйлчилгээнд зориулан нийт 306,100.0 мянган төгрөгийг тус тус баталсан байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт № 11

Он	Хүүхдийн тоо /эрсдэлт нөхцөл/	Төсвийн санал	Анх баталсан	Тодотгосон төсөв	Орон нутгаас НЦҮТ-д олгосон санхүүжилт
2019	300	49.0	47.2	47.2	41.0
2020	600	49.0	38.0	38.0	55.1
2021	419	49.0	49.0	49.0	60.0
2022	824	49.0	247.4	215.6	70.0
2023	1523	250.0	173.1	256.5	80.0
Нийт		446.0	554.7	606.3	306.1

Хүүхэд хамгааллын зардалд 2019-2023 онд нийт 912,400.0 мянган төгрөгийг тусган баталсан бөгөөд төсөв сүүлийн 2 жилд огцом нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүүхэд хамгааллын зардлын төсвийн төлөвлөлтөд хяналт хийхэд дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээнүүдийг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй
- урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдээр хэрэгжүүлэх ажлуудыг эрэмбэлэн ангилаагүй
- Сургалт зөвлөгөөний зардалд өдрийн цай, хоолны зардлыг ихээр төлөвлөсөн.

- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх нөхцөл байдлын үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажилд сумдын хамтарсан багуудад төсөв хуваарилж төлөвлөөгүй.
- Хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийг бууруулахад чиглэсэн бодитой арга хэмжээг төлөвлөж батлаагүй.
- Төсвийг алсагдсан сумдад хүүхэд хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр жигд хуваарилж тооцоогүй.

Дээрх зөрчил нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, 27 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-тай нийцэхгүй байна.

Төсвийг бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцоогүй, сумдад хүүхэд хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр зардал хуваарилаагүй, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлуудыг ангилан ялгаагүй байна.

2.1.2 Хүүхэд хамгааллын зардалд 2019-2023 онд нийт 597,100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. *Хүснэгт №12*

Он	Хүүхэд хамгаалал Батлагдсан төсөв	Хүүхэд хамгаалал Зардлын гүйцэтгэл	Зарцуулалт ангиллаар		
			Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх	Хамгаалах нөхөн сэргээх	Урьдчилан сэргийлэх
2019	47.2	47.2	0.0	47.2	0.0
2020	38.0	31.9	0.0	31.9	0.0
2021	49.0	48.1	0.0	48.1	0.0
2022	215.6	214.5	25.8	107.8	80.5
2023	256.5	256.0	18.5	187.4	50.1
Нийт	606.3	597.1	44.5	422.0	130.6

Төсвийн зарцуулалтыг ангиллаар нь авч үзвэл 2019-2023 онд Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 44,500.0 мянган төгрөг, Хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 442,000.0 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 130,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан үзүүлэлттэй байна.

Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх болон кейс үйлчилгээний зардалд 2022 онд 2,436.0 мянган төгрөг, 2023 онд 9,271.0 мянган төгрөгийг тус тус олгосон байна.

Аудитаар дээрх зардлуудын анхан шатны баримтыг түүвэрлэн үзэхэд дараах зөрчил илэрч байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын зардлаас уралдаан тэмцээний зардал,
2. Шагнал урамшуулал,
3. Хүүхдүүдэд нэг удаагийн шинжтэй багц олгох
4. Сургалт зөвлөгөөний хоолонд зарцуулсан зэрэг зөрчил илэрч байна.

Хүүхэд хамгааллын зардалд зарцуулахаар төсөвлөсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулж байгаа нь урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа болон хүүхдийн эрхийн зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулахад чиглэж чадахгүй байгааг харуулж байна.

Хүүхдийн тусламжийн дуудлагын 108 утсанд Хөвсгөл аймгийн хэмжээнд 2019 онд 103, 2020 онд 184, 2021 онд 212, 2022 онд 268, 2023 онд 293 нийт 1,060 дуудлага мэдээлэл ирсэн бөгөөд хүүхдийн эрх зөрчигдсөн дуудлага жил бүр нэмэгдсэн ба зөвхөн 2023 оны дуудлагын тоо өмнөх оноос 8.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Хүүхдийн эрх зөрчигдсөнтэй холбоотой дуудлага нэмэгдсээр байхад хүүхэд хамгааллын зардлаас уралдаан тэмцээний зардал, шагнал урамшуулал, бэлэг, нөхцөл байдлын үнэлгээ

хийгээгүй үед хүүхдүүдэд нэг удаагийн шинжтэй багц олгож, сургалт зөвлөгөөний хоолны зардалд төсвийг ихээр зарцуулж байгаа зэрэг нь төсвийг хүүхдийн эрхийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлийг бууруулахад бүрэн зарцуулахгүй байна.

2.1.3. Хүүхэд хамгааллын зардалд 2019-2023 онд нийт 606,300.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж 597,100.0 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Хүүхэд хамгааллын зардлын төсөв нь жил бүр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүүхэд хамгааллын зардлын төсөв: Хүснэгт №13

/сая.төг/

Он	Хүүхэд хамгаалал Батлагдсан төсөв	Хүүхэд хамгаалал Зардлын гүйцэтгэл	Орон нутгаас НЦҮТ-д олгосон санхүүжилт	Орон нутгаас НЦҮТ-д олгосон санхүүжилтийн зарцуулалтын гүйцэтгэл
2019	47.2	47.2	41.0	35.1
2020	38.0	31.9	55.1	53.9
2021	49.0	48.1	60.0	59.9
2022	215.6	213.9	70.0	63.0
2023	256.5	256.0	80.0	68.3
Дүн	606.3	597.1	306.1	280.2

Хүүхэд хамгааллын зардлын төсөв 2022 оноос нэмэгдсэн нь Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А23/27 дугаар тушаалаар баталсан Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нормативыг мөрдөж ажилласантай холбоотой байна.

Аудитаар Мөрөн сумын 14 баг, Улаан-Уул, Рэнчинлхүмбэ, Цагааннуур сумдын хамтарсан багуудын үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлэхэд хүүхэд хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулах төсвийг нөхцөл байдалд тулгуурлан хуваарилаагүй байгаа нь харагдаж байна.

Сумдын хүүхдүүдийг эрсдэлээс хамгаалах, сургалт нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах зардалд төсөв хуваарилан зарцуулаагүй нь төсөв санхүүгийн нөөцийг оновчтой тодорхойлж зардлыг жигд хуваарилаагүйг харуулж байна.

2.2. Хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд зарцуулах төсвийг оновчтой хуваарилаагүй, үр ашиггүй нийт 148,878.5 мянган төгрөгийн зардал гаргаж төсвийг хараа хяналтгүй зарцуулсан байна.

2.2.1. Хүүхэд хамгааллын зардалд улсын төсвөөс 2019-2023 онд нийт 606,300.0 мянган төгрөгийн төсвийг баталж 597,100.0 мянган төгрөгийг зарцуулсан, орон нутгийн төсвөөс 306,100.0 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, 280,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Хүүхэд хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд хяналт хэрэгжүүлэхэд төсвийг зориулалт бусаар зарцуулсантай холбоотой нийт 145,878.1 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Хүүхэд хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8,000.0 мянган төгрөгийг 2022 онд Хөвсгөл дулааны станц ТӨХК-д байгууллагын халаалт дулааны төлбөрт шилжүүлсэн.
- Аймгийн төвийн хурдан морины уралдаанч хүүхдүүдэд зориулж нэг хүүхдэд 14.0 мянган төгрөгөөр тооцон нийт 4,616.5 мянган төгрөгийн нэг удаагийн багцыг 330 хүүхдэд олгосон.
- Бүсийн чуулган, Уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, Хүн ам зүйн чиг хандлага ба гэр бүл нэгдсэн арга хэмжээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөгөөн зохион байгуулах зэрэг сургалт, арга хэмжээний хоолны зардалд 2022 онд 16,215.0 мянган төгрөг, 2023 онд 12,787.0 мянган төгрөгийг нийт 29,002.0 мянган төгрөгийг зарцуулсан.

- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 2022 онд 6,393.0 мянган төгрөг, 2023 онд 15,103.0 мянган төгрөг нийт 21,496.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг хүүхдүүдэд тараасан.
- Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний дэмжлэгийн зардалд 2022 онд 16,744.0 мянган төгрөг, 2023 онд 10,920.0 мянган төгрөг нийт 27,664.0 мянган төгрөгийн ариун цэврийн хэрэгсэл, ундаа, печенийн зардалд зарцуулсан байна. Гэвч эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийн ар гэрт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулах арга хэмжээнд зориулж нэг удаагийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан.
- Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээд 8,941.9 мянган төгрөгийг зарцуулснаас 5,246.0 мянган төгрөгийг хоол, үдийн цайны зардалд, үзүүлэх тоглолтын зардалд 1,000.0 мянган төгрөг нийт 6,446.0 мянган төгрөгийг зарцуулсан.
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх тухай ХГБХХГ-ын даргын 2023 оны А/200 дугаар тушаалаар нийт 25,174.0 мянган төгрөгийн багцыг олгосон хэдий ч сумдад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийгээгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоо мэдээлэл, судалгаа тодорхой болсон байхад 2023 онд шинээр эрсдэлийн үнэлгээ хийж илрүүлж байгаа мэтээр тайлагнаж хүүхдүүдэд багц тараасан нь үр ашиггүй зардал болсон байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4⁴, 16.5.5⁵, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3⁶ дахь заалтууд болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А23/27 дугаар тушаалаар баталсан “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний норматив”-тай тус тус нийцэхгүй байгаа тул **“Албан шаардлага”** тогтоохоор шийдвэрлэсэн.

- Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын төсвөөс Хөвсгөл аймгийн Хүүхдийн чуулганыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр холбогдох байгууллагуудад нийт 23,680,000 /хорин гурван сая зургаан зуун наян мянга/ төгрөгийн зардлыг шилжүүлсэн боловч одоог хүртэл зохион байгуулаагүй бөгөөд авлага үүсгээгүй, хоорондын тооцоогоор баталгаажуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.57, 13.68, 13.79 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй байгаа тул “Төлбөрийн акт” тогтоохоор шийдвэрлэсэн.

Хүүхэд хамгааллын чиглэлээр батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулснаас нийт 145,878.5 мянган төгрөгийн зөрчил илэрч байна.

2.2.2. Байгууллагын төсвийн ил тод байдлын талаар Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Шилэн дансны тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд төсвийн ил тод байдлыг хангаж, байгууллагын батлагдсан төсөв гүйцэтгэл, ажил гүйлгээ, төсөв, санхүү, өмч хөрөнгө захиран зарцуулах тушаал шийдвэрүүдийг олон нийтэд ил тод мэдээлэхээр тусгасан байна.

ХГБХХГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-д заасан мэдээллүүдийг шилэн дансны нэгдсэн мэдээллийн системд мэдээлж ажилласан байна.

⁴ 16.5.4 төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх;

⁵ 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;

⁶ 4.1.3.үр ашигтай байх;

⁷ 13.5.Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна;

⁸ 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна;

⁹ 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно;

ХГБХХГ нь хүүхэд хамгааллын зардлын төсөв төлөвлөлт гүйцэтгэлийн талаар хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлж байгаа оролцогч талуудад болон хамтарсан багийн гишүүдэд нээлттэй ил тод мэдээллийг өгөхгүй байгаагаас тус зардал хаана батлагддаг, ямар зардал байдаг талаар мэдлэг, мэдээлэлгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5¹⁰ дахь заалтай нийцэхгүй байна.

2.2.3. Хөвсгөл аймагт хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын зээл тусламжийн хөрөнгө оруулалтын талаар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ байхгүй байна.

Нэгдсэн үндэсний байгууллагын санхүүжилтээр ХГБХХГ-т 2020 онд 4,309.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 2022 онд 1,974.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 2023 онд 2,389.1 мянган төгрөг нийт 8,673.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн ба тавилга, тоног төхөөрөмжийг нягтлан бодох бүртгэлд бүртгэж хяналтад авсан байна.

2.2.4. Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар нь хүүхэд хамгааллын талаар дараах 7 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

- Аюулгүй байдлын хамгаалалт
- Сэтгэл зүйн үйлчилгээ
- Эрх зүйн үйлчилгээ
- Эрүүл мэндийн үйлчилгээ
- Нийгмийн халамжийн үйлчилгээ
- Хүүхэд хамгааллын үйлчилгээ
- Холбон зуучлах үйлчилгээ

Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлсэн ажил үйлчилгээний тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал.

Хүснэгт №14

№	Үйлчилгээ	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Аюулгүй байдлын хамгаалалт	125	132	158	155
2	Сэтгэл зүйн үйлчилгээ	364	331	128	27
3	Эрх зүйн үйлчилгээ	407	396	252	149
4	Эрүүл мэндийн үйлчилгээ	155	142	44	41
5	Нийгмийн халамжийн үйлчилгээ	68	32	32	43
6	Хүүхэд хамгааллын үйлчилгээ	163	136	176	195
7	Холбон зуучлах үйлчилгээ	92	41	30	53
Нийт үйлчилгээ		1374	2026	929	663

Хүснэгтээс харахад хүүхэд хамгааллын үйлчилгээний тоон мэдээллүүд буурсан үзүүлэлттэй байгаа нь хүүхэд хамгааллын үйлчилгээг хангалттай хэмжээнд үзүүлэхгүй байгааг харуулж байна.

Хүүхэд хамгааллын талаар цоц үйлчилгээг үзүүлэхэд дараах хүндрэл бэрхшээлүүд байна. Үүнд:

- Хүүхэд хамгааллын санхүүжилт нь ХГБХХГ-т батлагддаг бөгөөд сумдын хамтарсан багууд хүүхдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зардалгүй
- Хамтарсан багийн гишүүд нь орон тооны бус, үндсэн чиг үүргийн ажлын хажуугаар давхар ажилладаг.
- Орон нутагт хүүхэд хамгаалах түр байр байдаггүй
- Хамтарсан багийн гишүүд нь тогтвор суурьшилгүй
- Орон нутагт мэргэжлийн сэтгэл засалч байдаггүй
- Аймгийн хэмжээнд 1 байдаг нэг цэгийн үйлчилгээний байрны хүрэлцээ муу, орчин нөхцөл стандартын шаардлагад нийцээгүй

¹⁰ Энэ хуулийн 16.5.4. заасан төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Сумын төвд архи, согтууруулах ундаа хэрэглэсэн этгээдийг хүүхдээс тусад нь байлгах саатуулах байр байхгүй
- Хүүхдийн асрамжийн үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллага байхгүй зэрэг хүндрэлүүд байна.

Дээрх шалтгаануудын улмаас аймгийн хэмжээнд хамтарсан багийн үйл ажиллагаа жигдэрч тогтмолжоогүй, хүүхдийн хүчирхийллийн талаар дуудлага мэдээлэл ирэхэд багийн гишүүд нь бүрэн цуглаж, хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд жигд оролцдоггүй, яаралтай тусламж үзүүлэх болон нөхцөл байдлын үнэлгээ хийх, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.

Хамтарсан багийн хэрэгжүүлж байгаа ажил үйлчилгээний чиг үүргийг Хүүхэд хамгааллын тухай хуульд тусган зааж өгсөн учир хуулийн шаардлагын дагуу ажиллаж байгаа бөгөөд хүүхэд хүчирхийлэлд өртсөн тохиолдолд л хариу арга хэмжээг үзүүлэх байдлаар ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхой хэмжээнд үзүүлж байгаа хэдий ч сум орон нутагт хүүхэд хамгаалах байргүй, сумдын хамтарсан багуудад хүүхдийг эрсдэлээс хамгаалах урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд төсөв зарцуулаагүй, нэг цэгийн үйлчилгээний байрны орчин нөхцөл стандартын шаардлагад нийцээгүй, хүүхэд эрсдэлд өртсөн тохиолдолд л хариу арга хэмжээ авч ажилласан бөгөөд хүүхдийн эсрэг хүчирхийллийг арилгахад чиглэсэн бодитой ажлыг хийгээгүй зэрэг нь хүүхэд хамгааллын үйлчилгээг цогцоор нь хэрэгжүүлэх боломж бүрдээгүй байна.

2.2.4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хамтарсан багийн үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1-д Үйлчлүүлэгчийн тулгарсан асуудал, үйлчилгээний холбоотой мэдээллийг нууцлахыг хүссэн зүйл өөрт нь эсхүл бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байх, хамтарсан багийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болохоос бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн нууцлалыг хуулийн дагуу хадгалах үүрэг хүлээнэ гэж заасан байна.

Аудитаар санхүүгийн анхан шатны баримт материалуудад хяналт хийхэд хувь хүний нууцтай холбоотой баримт мэдээлэл агуулагдаагүй байна.

Хамтарсан багуудын үйл ажиллагаанд хяналт хийхэд хувь хүний нууцыг хадгалах орчин нөхцөл бүрдээгүй энэ талаар ХГБХХГ-аас заавар зөвлөмж өгч холбогдох арга хэмжээг авч хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна. **Тухайлбал:** Хамтарсан багийн гишүүдтэй нууцын гэрээ байгуулаагүй, Нууцын баталгаа гаргуулаагүй, баримт бичиг хадгалах тусгай сейф байхгүй, баримт материал кейсүүд нь албан хаагчийн ширээн дээр ил байрлаж байгаа нь хувь хүний нууц алдагдах эрсдэлтэй байна. Энэ нь хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.13¹¹ дахь заалт, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/173, А/251, А/380 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Хамтарсан багийн үйл ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.1¹²-д заасантай тус тус нийцэхгүй байна.

2.2.6 Хүүхэд хамгааллын зардалд 2019-2023 онд нийт 606,300.1 мянган төгрөгийн төсвийг баталж 597,100.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

¹¹ 18.2.13.мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах үйл ажиллагааны явцад олж авсан мэдээллийг хадгалах;

¹² Үйлчлүүлэгчийн тулгарсан асуудал, үйлчилгээний холбоотой мэдээллийг нууцлахыг хүссэн зүйл өөрт нь эсхүл бусад хүмүүсийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх өндөр эрсдэлтэй байх, хамтарсан багийн гишүүд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь саад болохоос бусад тохиолдолд үйлчлүүлэгчийн нууцлалыг хуулийн дагуу хадгалах үүрэг хүлээнэ

Хүснэгт №15

Он	Хүүхэд хамгаалал Батлагдсан төсөв	Хүүхэд хамгаалал Зардлын гүйцэтгэл	Зарцуулалт ангиллаар		
			Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх	Хамгаалах нөхөн сэргээх	Урьдчилан сэргийлэх
2019	47.2	47.2	0.0	47.2	0.0
2020	38.0	31.9	0.0	31.9	0.0
2021	49.0	48.1	0.0	48.1	0.0
2022	215.6	2014.5	25.8	107.8	80.5
2023	256.5	256.0	18.5	187.4	50.1
Нийт	606.3	597.1	44.5	422.0	130.6

Төсвийн зарцуулалтыг ангиллаар нь авч үзвэл 2019-2023 онд Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ хийх зардалд 44,500.0 мянган төгрөг, Хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардалд 442,000.0 мянган төгрөг, урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 130,600.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Хүүхэд хамгааллын зардлын хуваарилалтад хяналт хийхэд дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдээр хэрэгжүүлэх ажлуудыг эрэмбэлэн ангилаагүй
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийг илрүүлэх нөхцөл байдлын үнэлгээ хийх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх ажилд сумдын хамтарсан багуудад төсөв хуваарилж зарцуулаагүй.

Энэ нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2022 оны А/23, 27 дугаар тушаалаар баталсан "Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив"-тай нийцэхгүй байна

Төсвийг эрсдэлт нөхцөлд байгаа болон сумдад байгаа хүүхдийн тоонд үндэслэж хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр зардал хуваарилаагүй нь хүүхэд хамгааллын үйлчилгээг хамгаалал шаардлагатай хүүхдүүдэд бүрэн үзүүлэх боломжгүй нөхцөлийг үүсгэж байна.

В. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ТАЛААР БАРИМТАЛЖ БУЙ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ БАТЛАГДААГҮЙ, ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮНГ ТООЦОЖ АЖИЛЛААГҮЙ БАЙНА.

3.1 Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж байгаа хууль, журам, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-үнэлгээ хийх аргачлал батлагдаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдсан, үр дүнг тооцох боломжгүй байна.

3.1.1 Хүүхдийн эрх, хамгаалалд чиглэгдсэн оролцогч талуудад хүүхдийн төлөө зөвлөл, хамтарсан баг, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүнд орсон салбар салбарын байгууллагаас төлөөллүүд орон ажиллаж байна. Хүүхэд хамгаалалд оролцогч талуудыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №16

№	Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16.2	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн 20.1	Хүүхэд хамгааллын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 40.2
	Хүүхдийн төлөө зөвлөл-13 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй	Хамтарсан баг-7-9 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо-12 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй

Оролцогч талуудын хамтын ажиллагаа нь хүүхэд хамгааллын тогтолцооны нэг хэлбэр байхаар тусгасан хэдий ч тухайн салбарын үйл ажиллагааны онцлогт нийцсэн байдлаар үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт, нарийвчилсан аргачлалгүй байна.

Хүүхдийн төлөө зөвлөлийн талаар: Хүүхдийн төлөө зөвлөлийг Хөвсгөл аймгийн Засаг даргын 2023 оны А/144 дугаар тогтоолоор 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталсан ба Хүүхдийн хамгааллын тухай хуулийн 21.1¹³, 21.2¹⁴, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлд чиг үүргийг тодорхойлсон байна. Орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөлийн 2019 оны 04 сарын 04-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөж байгаа бөгөөд тус зөвлөлийн гишүүдийн эрх үүргийг тусган хэрэгжүүлж байгаа ч гишүүд нь чиг үүргийн дагуу шаардлагатай мэдээлэл, саналыг зөвлөлийн хуралд оруулан хэлэлцүүлж, идэвх санаачилгатай ажиллана гэснээс өөрөөр зөвлөлийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж дүгнэхийг зохицуулсан шалгуур аргачлалгүй байна.

Орон нутагт 2019-2023 онуудад хүүхэд хамгаалалтай холбоотой аймгийн ИТХ -ын 1 тогтоол, Засаг даргын 3 захирамж, 2 албан даалгавар, Хүүхдийн төлөө зөвлөлийн 1 тогтоол гарсан байна. Гарсан тогтоол шийдвэрийг огноогоор нь харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №17

№	Тогтоол, шийдвэр	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Аймгийн ИТХ-ын тогтоол	-	-	-	-	“Хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих” 2023.12.01-ны өдрийн № 02
2	Аймгийн Засаг даргын захирамж	-	“Хүүхдийн эрхийг хамгаалах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх тухай” 2020.11.13-ны өдрийн А/592	-	-	- “Хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох тухай” 2023.03.21-ний өдрийн А/112 - “Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай” 2023.05.23-ны өдрийн А/268
3	Аймгийн Засаг даргын албан даалгавар	-	“Хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хамгааллыг сайжруулах тухай” 2020.04.15-ны өдрийн № 02			“Аймгийн хүүхдийн ХI чуулганы шийдвэрийг хэрэгжүүлэх тухай” 2023.01.06-ны өдрийн № 01
4	Хүүхдийн төлөө зөвлөлийн тогтоол	“Хүүхдийн эрхийг хангах, эрх нь зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 2019.04.24-ний өдрийн №2	-	-	-	-

Орон нутагт гарсан дээрх тогтоол шийдвэрүүдээс 2020 онд гарсан шийдвэрүүд нь цар тахлын үед авсан арга хэмжээ байгаагаас харахад хүүхдийн төлөө зөвлөл нь 2020-2022 онуудад хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Зөвлөлийн үйл ажиллагааг хянахад дараах зөрчил байна. Үүнд:

1. 2019-2023 оны хооронд 1 удаа / /2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр/ хуралдаж хуралдааны тэмдэглэлийг албажуулсан ба өмнөх онуудад зөвлөлийг хуралдуулж хүүхэд хамгаалалтай холбоотой асуудлыг хэлэлцсэн гэх боловч баримтаар нотлогдохгүй байна.
2. Хөвсгөл аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын чиглэлээр дараах чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал:

¹³ Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

¹⁴ Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл жил бүрийн 3 дугаар улиралд багтаан хүүхэд хамгааллын тайлан гаргаж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны байгууллагад чиглэл, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад байгууллагад зөвлөмж өгч, бодлого тодорхойлох, шийдвэр гаргах эрх бүхий оролцогч талуудад санал оруулна.

- Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ 2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад хэрэгжүүлээгүй.
- Хүүхэд хамгааллын талаар 2019-2023 онуудад хийсэн ажлын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаж үр дүнг олон нийтэд мэдээлээгүй байна.
- Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулаагүй зэрэг зөрчил илэрсэн.

Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхдийн эрх, хамгаалалд оролцогч талуудын үйл ажиллагааг үнэлж дүгнэх шалгуур үзүүлэлт байхгүйгээс хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд идэвх санаачилгагүй хандаж байгаа бөгөөд үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хамтарсан багийн үйл ажиллагааны талаар: Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 5.1.4. “хамтарсан баг” гэж хохирогч, түүний гэр бүлийн гишүүнд энэ хуулийн 37, 38.1.1, 40, 41, 42 дугаар зүйлд заасан үйлчилгээг хамтран үзүүлэх сум, хорооны Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэрийг хэлнэ гэж заасан байна.

Хамтарсан баг нь дараах чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

- ✚ Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг илрүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлэх;
- ✚ Хүүхдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох, хүүхэд аюултай нөхцөл байдалд орсон бол шуурхай тусламжийн үйлчилгээг үзүүлэх;
- ✚ Хүүхэд эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн байгууллага, магадлан итгэмжлэгдсэн хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулах;
- ✚ Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, түүний гэр бүлд үзүүлэх хүүхэд хамгааллын үйлчилгээний төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих;
- ✚ Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуучлах ажлыг зохион байгуулах;
- ✚ Тухайн жилд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах төсвийн саналыг харьяа хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад хүргүүлэх

Хөвсгөл аймгийн хэмжээнд нийт 38 хамтарсан баг нь 301 орон тооны бус албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр хүүхэд хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлж байна.

Хамтарсан багийн 2019-2023 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Хүснэгт №18

Он	Бүртгэгдсэн кейсийн	Шийдвэрлэсэн кэйсийн тоо	Кейс шийдвэрлэлтийн хувь	Ажиллаж байгаа кейсийн тоо	Нөхцөл байдлын үнэлгээний тоо
2019 он	169	98	58%	71	169
2020 он	210	172	82%	38	210
2021 он	148	95	64%	53	316
2022 он	197	161	82%	36	236
2023 он	217	116	53.5%	101	91
Дүн	941	642	68.2%	299	1,022

Хүснэгтээс харахад 2019-2023 онд нийт 941 кейс нээж 642 буюу 68.2 хувийг нь шийдвэрлэсэн байна.

Аудитаар нийт 38 хамтарсан баг ажиллаж байгаагаас 17 хамтарсан багийн үйл ажиллагаатай танилцаж, хэрэгжүүлсэн ажлын баримт материалд хяналт хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудлууд байна. Үүнд:

1. Хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг хууль журамд заасны дагуу хадгалаагүй.
2. Хамтарсан баг хуралдсан тухай бүр хурлын тэмдэглэлийг хөтөлж албажуулаагүй байна.

Аудитын ажиглалтаар хамтарсан багийн гишүүд нь үндсэн ажилтай, мэргэжлийн боловсон хүчнээр дутмаг, хурлын ирц бүрддэггүй зэргээс харахад хүүхэд хамгааллын кейс менежментийг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

3.1.2. УИХ-аас 2016 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3¹⁵-д зааснаар Хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдал, хууль журмын хэрэгжилтийн хяналт-үнэлгээ хийх чиг үүрэг нь орон нутгийн Хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагад байна.

Аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар нь 2019, 2020, 2021, 2022 2023 онуудад Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд 3-н жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар төрийн захиргааны байгууллага буюу Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газарт тус чиг үүрэг шилжсэн байна.

3.1.3. НҮБ-ын Хүүхдийн эрхийн Конвенцын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын Засгийн газрын 5-р тайланд 26 чиглэлээр 84 зөвлөмжийг өгсөн байна. Хүүхэд хамгааллын талаар өгсөн ихэнх зөвлөмжүүд нь орон нутгийн түвшинд хангалттай хэрэгжиж байна. Үүнээс хэрэгжихгүй байгаа дараах зөвлөмжүүд байна. Үүнд:

Хүүхдийн хөдөлмөр, унаач хүүхэд зэрэг эдийн засгийн мөлжлөг.

- (a) Жил бүрийн 11 дүгээр сарын 1-ээс тавдугаар сарын 1-нийг хүртэлх хугацаанд 16-аас доош насны хүүхдээр хурдан морь унуулахыг хориглосон шийдвэрийг 18 наснаас доош хүүхдээр хурдан морь унуулахыг хориглох үйл явцын эхний алхам гэж үзэн хэрэгжилтийг нь сахиулахад хатуу анхаарах.
- (b) Хурдан морины уралдаанд оролцож байгаад хүндээр гэмтсэн амь насаа алдсан хүүхдүүдийн хэргийг мөрдөн шалгаж буруутай этгээдэд хариуцлага ноогдуулах;
- (c) Хурдан морины уралдаан гэх мэт аюултай, хортой хүүхдийн хөдөлмөрт хүүхдийг оролцуулдаг бизнес эрхэлж буй төрийн албан хаагчдын хувийн болон албаны ашиг сонирхлын зөрчил гаргаж буй үйлдэлд арга хэмжээ авах, ийм үйлдэл гаргуулахгүй байхад чиглэсэн хээл хахуулийн эсрэг арга хэмжээнүүдийг авах.

Дээрх зөвлөмжүүд нь Монгол улсын үндэсний их баяр наадам, өв соёл, морин уралдаантай холбоотой асуудал учраас улсын хэмжээнд нэгдсэн бодлого зохицуулалттай арга хэмжээ авч ажиллаагүй нөхцөлд орон нутагт бие даан шийдвэр гарган зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах боломжгүй байна.

3.1.4. Хөвсгөл аймагт хүүхэд хамгааллын чиглэлээр олон улсын байгууллага болон төрийн бус байгууллагаас хэрэгжүүлсэн үйл ажиллагааны баримт материалыг Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газарт татан авсан тул орон нутагт хянах баримт материал байхгүй байна.

3.1.5. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар 09-ний өдрийн 03-р тогтоолоор баталсан “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийн хэрэгжилтэд хуульд заасны дагуу орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна. Хүүхдийн төлөө зөвлөл нь 2019-2023 онуудад хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт хэрэгжүүлээгүй ба үнэлэх, шалгуур, аргачлал батлагдаагүйтэй холбоотой байна.

¹⁵ Хүүхдийн эрхийн тухай хууль болон энэ хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд нэгээс доошгүй удаа анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийх

3.1.6. Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг нь батлагдсанаас хойш тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилт үр дүнг үнэлэх, шалгуур үзүүлэлт, аргачлал одоог хүртэл батлагдаагүй байна.

3.1.7. Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хүрээнд 2023 оны байдлаар Хөвсгөл аймагт үйл ажиллагаа явуулж байгаа 500 гаруй байгууллагаас 201-н байгууллага эцэг эхийн зөвлөлийг байгуулан ажиллаж байна. Үүнээс: 51 байгууллага нь хүүхэд хамгааллын бодлого боловсруулан мөрдөж ажиллаж байгаа бол 20 байгууллага нь хүүхдэд зориулсан тусгай “хүүхдийн өрөө”-тэй байна. Тухайлбал: Аймгийн Засаг даргын тамгын газар, аймгийн Шүүхийн тамгын газар, Аймгийн ЗДТГ-ын тухайд байгууллагын дэргэд хүүхдийн өрөөг ажиллуулж байгаа бөгөөд өдөр өнжүүлэх, хөгжүүлэх хэлбэрээр ашиглаж байна.

Хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгийн хүрээнд хүүхдийн төлөө зөвлөлөөс тодорхой ажлыг зохион байгуулж байгаа хэдий ч эерэг нөлөөг тооцоогүй бөгөөд тус эерэг нөлөөг тооцож үнэлэх тогтолцоо бүрдээгүй байна.

Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж байгаа хууль, журам, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-үнэлгээ хийх аргачлал батлагдаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдсан, үр дүнг тооцох боломжгүй байна.


3.2. Цахим, гэр бүл, сурч боловсрох орчны хүчирхийллээс хүүхдийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх сургалт сурталчилгааг хангалттай зохион байгуулаагүй зэргээс харахад хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

3.2.1. Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 03 дугаар тогтоолоор байгууллага, хуулийн этгээдийг ажил, үйлчилгээ үзүүлэх болон албан хаагчдаараа дамжуулан гэр бүл, нийгмийн хүрээнд хүүхдийн аюулгүй байдлыг хангах, хүүхэдтэй зүй бус харилцах, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрсдэлт нөхцөлд орохоос урьдчилан сэргийлэх, хамгаалахад хүлээсэн үүрэг, хариуцлагаа биелүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх зорилгоор “Хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримт бичиг”-ийг баталсан байна.

Уг жишиг бодлогын баримт бичигт байгууллага бүр хүүхэд хамгааллын асуудлаар ажиллах эцэг, эхийн зөвлөлийг байгуулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг тодорхойлж өгсөн ба түүний хүрээнд дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 206 байгууллага хүүхэд хамгааллын эцэг, эхийн зөвлөлийг байгуулсан ба 2020 онтой харьцуулахад 89 байгууллагаар нэмэгдсэн байна.

График №1



- Нийт 51 байгууллага хүүхэд хамгааллын бодлогын жишиг баримтын хүрээнд байгууллагын онцлогт тохирсон бодлого боловсруулан мөрдөж ажиллаж байна.
- Байгууллагын ажилчдын хүүхдийг өдөр өнжүүлэх зориулалтын өрөөтэй 20 байгууллага байна

- Хөвсгөл аймгийн ХГБХХГ-аас эцэг, эхийн зөвлөлүүдийн төлөөлөл 120 хүнийг сургагч багшаар бэлтгэсэн байна. Бэлтгэгдсэн сургагч багш нар байгууллагын ажилтан, албан хаагч, тэдний гэр бүлд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 4,400 хүнд хүрч ажилласан тоо мэдээ байна.

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хүүхэд хамгааллын бодлогын ажлыг таниулах, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах ажлыг хэрэгжүүлж байгаа боловч гэр бүлийн орчинд нөлөөлж буй нөлөөллийн талаарх үнэлгээ хийх аргачлал батлагдаагүйгээс үр дүнг тооцоогүй байна.

3.2.2 Хөвсгөл аймгийн хэмжээнд 34 ерөнхий боловсролын сургууль, 46 дотуур байр, Төрийн 43, хувийн 3 цэцэрлэг тус тус үйл ажиллагаа явуулж байна. Дотуур байранд 3,376 хүүхэд Ерөнхий боловсролын сургуульд 30,828 хүүхэд, Цэцэрлэгт 8,031 хүүхэд сурч боловсорч байна.

Боловсролын салбарын хүүхэд хамгааллын үйл ажиллагааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 23 дугаар зүйлд тодорхойлсон байна. Ерөнхий боловсролын сургуулиуд нь хүүхэд хамгааллын бодлогыг боловсруулан баталж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Боловсролын салбар 2023 оноос эхлэн Засгийн газрын "Хувьсах зардлын хэмжээ, итгэлцүүр, журам батлах тухай" 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор баталсан журамд Хүүхэд хамгааллын зардлыг аймагт нийт хувьсах зардлын 0.248 хувь, суманд нийт хувьсах зардлын 0.218 хувь байхаар тусгаж өгсөн байна.

Боловсрол шинжлэх ухааны газар болон ерөнхий боловсролын сургууль, дотуур байрнуудыг түүвэрлэн хяналт хийхэд Хөвсгөл аймгийн хэмжээнд Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам"-ын хэрэгжилт хангалтгүй байна. **Тухайлбал:** Цагааннуур, Рэнчинлхүмбэ, Улаан-Уул сумын ЕБС, Мөрөн сумын Эрдмийн далай цогцолбор сургууль, Дэлгэрмөрөн цогцолбор сургууль, ШУТИС-ийн харьяа политехникийн коллеж дээр ажиллахдаа захирал, байрын багш, мэргэжилтэн нартай уулзаж ярилцахад дээрх журмын талаар мэдээлэлгүй байна.

Аудитаар дараах эрсдэлтэй асуудлууд илэрсэн. Үүнд:

- Хөвсгөл аймгийн хөдөө сумдын сургуульд суралцаж буй малчин өрхийн хүүхдүүдэд дотуур байрны хүрэлцээ хангалтгүй байгаагаас хүүхдийг айлд тавьж байлгах, өрх толгойлон гэр барьж амьдрах зэрэг хүүхдийн эрх зөрчигдөх, хүүхэд хамгаалал алдагдах эрсдэлтэй нөхцөл байдал үүссэн.
- ШУТИС-ийн харьяа Политехникийн коллеж нь Хөвсгөл аймгийн бусад сургуулиудаас сургалтын тогтолцоо нь ялгаатай, тухайн сургуулийн хүүхдүүд гэмт хэрэгт холбогдох эрсдэл өндөр байна. БШУЯ-ны салбарын байгууллагаар шилжиж ирээд 2 дахь жилдээ үйл ажиллагаа явуулж байгаа тул тухайн коллежид зориулж хүүхэд хамгаалал болон бусад чиглэлээр тусгайлсан ажлыг зохион байгуулаагүй
- ЕБС-ийн багш ажилчидтай уулзаж ярилцахад хүүхэд хамгаалал болон бусад чиглэлээр олон сургалт, аяныг зохион байгуулж байгаа боловч хэрэгжүүлж буй байгууллага нь талбар дээр гардаж үр дүнтэй ажилладаггүй, хэрэгжилтийн тайланг гаргадаггүй.
- Хөвсгөл аймгийн хэмжээнд БШУ-ны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам", Боловсрол шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан сургуулийн өмнөх боловсролын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт хангалтгүй
- Хөвсгөл аймгийн Боловсрол шинжлэх ухааны газраас Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаагүй

3.2.3. Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын үйл ажиллагааг Хүүхэд хамгааллын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-24.4 дахь заалтад тусгасан байна.

Эрүүл мэндийн салбарын 2021-2023 онд хүүхэд хамгааллын чиглэлээр үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тоон мэдээлэл.

График №2

График №3





График №4

График №5



Графикаас харахад охидын жирэмслэлт болон эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа хүүхдүүдийн тоон мэдээлэл өссөн, Осол гэмтэл, гаднын нөлөөнөөс болж гэмтсэн болон түргэн тусламж үйлчилгээ авсан хүүхдүүдийн тоон мэдээлэл буурсан үзүүлэлтэй байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/240 дүгээр тушаалаар “Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллын журам”-ыг баталсан байна.

Хөвсгөл аймгийн Эрүүл мэндийн газар нь хүүхдийн эрүүл мэндэд чиглэсэн үндэсний эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг орон нутагтаа жил бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.


Эрүүл мэндийн газар нь:

- Нөхөн үржихүйн насанд хүрсэн эмэгтэйчүүдэд өгөх сургалт
- Жирэмсний эрт хяналт
- Нярайн эргэлт
- Хүнс, хоол тэжээлийн хяналт
- СӨБ, ЕБС-ийн орчин дахь эрүүл ахуйн хяналт хийх зэргээр хүүхдэд чиглэсэн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлж байна.

Хөвсгөл аймгийн Нэгдсэн эмнэлэгт өсвөр үеийн кабинет ажиллаж байгаа боловч үндсэн орон тооны бүтэцгүй, 1 эмч, 1 эх баригч хавсран хариуцаж байна.

Хөвсгөл аймгийн ЭМГ-т Дэлхийн зөн ОУБ-ын санхүүжилтээр өсвөр үеийнхэнд мэдээлэл, сургалтын чиглэлээр 1 кабинет ажиллаж байна. Тус кабинет нь дэргэдээ 8-11 дүгээр ангийнхнаас бүрдсэн 2 клубтэй болсон байна. Өсвөрийн клубүүд нь аймгийн төвийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд санхүү, төсөв байхгүйн улмаас хөдөө сумдад мэдээлэл, сургалт явуулах боломжгүй байна.

График №8



Хөвсгөл аймгийн хэмжээнд 2024 оны байдлаар 23 хүүхдийн эмч ажиллаж байна.

Хөвсгөл аймаг нь 23 хөдөөгийн сум, аймгийн төвийн 14 багтай бөгөөд хүүхдийн эмчийн хүрэлцээ хангалтгүй байна.

Хүүхдийн цэцэрлэг, ЕБС-д эрүүл мэндийн сургалт болон бусад үйл ажиллагааг явуулахад тухайн сургууль, цэцэрлэгийн эмчтэй хамтран ажиллах шаардлага гарч байна. Зарим тохиолдолд салбар дундын ажлын уялдаа муугаас боловсролын салбарт ажиллаж байгаа эмч нартай аймгийн ЭМГ-аас шууд харьцаж ажиллах боломжгүй байдгаас аймгийн БШУГ-т хандах асуудал тулгарч байна.

3.3.4. “Хүүхэд хамгааллын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлд Хэвлэл, мэдээлэл, цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаар тусгаж өгсөн байна. Уг хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсэгт цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журмыг цахим хөгжил, харилцаа холбооны, хүүхэд, гэр бүлийн хөгжлийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар заасны дагуу төслийг боловсруулан танилцуулах ажлыг хэрэгжүүлж байна.



мэдээллийг шүүж насны онцлогт тохирсон мэдээллийг санал болгох тохиргоотой байна. Гэвч эцэг, эх, асран хамгаалагчдад энэ талаар мэдлэг мэдээлэлгүй тул дээрх тохиргоог хийх мэдлэггүй байна. Иймд хүүхдийг сөрөг мэдээллээс хамгаалах мэдлэг олгох арга хэмжээг авч ажиллах нь чухал байна.

Төрийн зүгээс хүүхдэд сөргөөр нөлөөлөх мэдээ, мэдээлэл, төрөл бүрийн контентыг хориглож хуулиар зохицуулсан боловч мэдээллийг хүлээн авах шатанд тухайн хүүхдийн насны онцлогт тохируулан шүүх аргачлалыг хэрэгжүүлж чадахгүй байна. Дэлхий нийтэд түгээмэл ашигладаг Facebook, Youtube, Google зэрэг олон нийтийн сүлжээ нь хүүхдэд хориглосон



Аудитаар дараах зөрхилтэй асуудлууд илэрлээ. Үүнд:

- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, хувь хүмүүс нийгмийн хариуцлагын хүрээнд сайн үйлсийн аян гэх мэтээр бүтэн өнчин болон амьжиргааны түвшин доогуур айл, өрхийн хүүхдүүдэд тусламж үзүүлэхдээ тухайн хүүхдийн зураг, бусад мэдээллийг олон нийтийн сүлжээнд байршуулдаг.
- Мөн хувь хүмүүсийн хоорондын хэрүүл маргаан, өр төлбөртэй холбоотой хувийн чанартай мэдээллийг тухайн аймаг, сум, орон сууц, хорооллын facebook группт оруулж байгаа нь хүүхдийн эрхийг шууд болон гэр бүлээр нь дамжуулан зөрчиж нэр хүндэд нь халдаж байгаа зэрэг зөрчил илэрсэн.

3.2.5. Олон нийтийн арга хэмжээ, Соёл, спортын үйл ажиллагаа дахь хүүхэд хамгааллын талаар Хүүхэд хамгааллын тухай хуулийн 27 дугаар зүйлд харилцагч талуудын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, авах арга хэмжээний талаар тургасан байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" журмыг баталсан байна. Уг журамд соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагааг зохион байгуулагч болон оролцогч талуудын хүүхэд хамгааллын үүргийг тусгайлан зааж өгсөн байна.

Хөвсгөл аймгийн ХГБХХГ нь тухайн жилд зохион байгуулах хүүхдийн соёл, спортын үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, баталж байна. Боловсролын бүх шатны байгууллагууд нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнд хүүхдүүдийг бэлтгэн оролцуулах бодлого барин ажиллаж байна.

Аудитаар Хөвсгөл аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Биеийн тамир спортын газар, Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын үйл ажиллагаанд **Соёл, спортын үйл ажиллагаанд хүүхэд хамгааллыг хэрэгжүүлж байгаа талаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрсэн. Үүнд:**

Тэмцээнд: Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сум, сургуулийн 12-14 насны тамирчид оролцох ба 2010-2012 онд төрсөн тамирчин сурагчид оролцоно.

Гурав. Тэмцээн явагдах хугацаа, техникийн зөвлөгөөн:

Тэмцээн 2024 оны 9 дүгээр сарын 21-ээс 10 дугаар сарын 21-ний өдрүүдэд Хөл бөмбөгийн талбайд явагдана. Техникийн зөвлөгөөн 2024 оны 9 дүгээр сарын 18-ны 16 цагт БТСГ-т болно.

Дөрөв. Тэмцээний журам

- Багууд тоглолт эхлэхээс 30 минутын өмнө талбайд ирсэн байх.
- Нэг баг 12 тамирчинтай байна.
- Шууд улаан карт авсан тамирчин 3 тоглолт өнжинө 2 шар картаар 1 тоглолт өнжинө.
- Багууд заавал жигдэрсэн өмсгөл, гидер, шитоктой байна.
- Бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр ярилцана.
- Лигийн тэмцээнд оролцох эрхийн төлбөр мандат 15,000 төгрөг.

биелүүлэхгүй байна.

- ХГБХХГ-аас соёл, спортын арга хэмжээнд оролцож буй хөгжлийн бэрхшээлтэй болон бүтэн өнчин, 13 хүртэлх насны хүүхдээс төлбөр хураамж авахгүй байх заалтыг хэрэгжүүлж буй талаар хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Дээрх зөрчлүүдийг арилгах, хүүхдийг хамруулсан олон нийтийн арга хэмжээ, соёл, спортын үйл ажиллагаанд зохион байгуулагчдад хүүхэд хамгааллын тухай хууль, журмын мэдлэг олгох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

3.2.6. УИХ-ын 2016 онд баталсан “Хүүхэд хамгааллын тухай хууль”-д гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын тухай тусгаагүй байна. Харин тус хуулийн шинэчилсэн найруулгын 28 дугаар зүйлд дээрх асуудлыг тусгаж өгсөн байна. Засгийн газрын 2019 оны 201 дүгээр тогтоолоор “Онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж дэмжлэг үзүүлэх журам”-ыг баталсан байна.

Дээрх журмын 2.1¹⁷, 2.2¹⁸-д заасны дагуу Онцгой байдлын газар нь онцгой нөхцөл байдлын үеийн хүүхэд хамгааллын талаар сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах чиг үүрэгтэй хэдий ч хүүхдүүдэд зориулсан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюул тохиолдсон үед амь нас, эрүүл мэндээ хамгаалах талаар сургалтыг зохион байгуулж, олон нийтэд сурталчилж байгаа боловч онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар сургалт, сурталчилгааг хийхгүй байна.

Цахим, гэр бүл, сурч боловсрох орчны хүчирхийллээс хүүхдийг бүрэн хамгаалж чадахгүй байгаа, гамшгийн үеийн хүүхэд хамгааллын талаарх сургалт сурталчилгааг хангалттай зохион байгуулаагүй зэргээс харахад хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний хэрэгжилт үр дүнгүй байна.

¹⁶ Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах журам”

¹⁷ Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн амь нас, аюулгүй байдлыг хангах, хүүхдийн бүх төрлийн дарамт, хүчирхийлэл, үл хайхрах явдал, мөлжлөгөөс хамгаалуулах эрхийг хангахын тулд цаг алдалгүй тусламж, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хүүхэд, гэр бүлийн хөгжлийн, боловсролын, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага нь нутгийн захиргааны байгууллага, цагдаа, онцгой байдлын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах улсын албад, дотоодын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.

¹⁸ Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусламж, дэмжлэг үзүүлэх талаар энэ журмын 2.1-д заасан бүх байгууллага, алба улирал бүр харьяалах салбар, нутаг дэвсгэртээ сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулна.

3.3. 6. Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдийн гэр бүлийн орчны хүчирхийллийг арилгах үйлчилгээ байхгүй нь хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үед дахин хохирогч болох эрсдэл байсаар байна.

3.3.1. Монгол улс хүүхдийн эрхийн конвенцод 1990 онд нэгдэн орсон бөгөөд монгол улсын олон улсын гэрээ, хүүхдийн эрхийн конвенцыг 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр баталсан байна.

Тус конвенцод нийт 54 зүйлийг тусгасан бөгөөд хүүхдийн эрх тэгш, боловсрох, хөгжих, хамгаалуулах талаарх арга хэмжээнүүдийг тусган баталсан байна.

Хөвсгөл аймгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд хүүхдийн эрхийн конвенцын үндсэн агуулгад нийцүүлэн зорилт, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлсэн байна.

Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар болон хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд оролцогч талууд нь хамгааллын талаарх хууль тогтоомжууд, засгийн газраас баримталж буй бодлого, дүрэм журам арга хэмжээнүүд болон хүүхдийн эрхийн конвенцод туссан арга хэмжээнүүдийг байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.3.2. Монгол улсын хувьд Хүүхдийн Төлөө Үндэсний газраас Хүүхдийн тусламжийн утасны үйлчилгээг 2005 онд “Дотно утас 1979” нэртэйгээр анх нээн ажиллуулж эхэлсэн. 2006 онд Олон улсын Хүүхдийн Тусламжийн утасны сүлжээ /Child Helpline International/- д элсэн орж, 2008 онд гишүүнчлэлийн статустай болсон байна.

2014 онд “Дотно Утас 1979”-ийн судалгаа, хэрэгцээнд тулгуурлан Хүүхдийн тусламжийн 108 утас нэртэйгээр Монгол улсын хэмжээнд үйлчилгээ үзүүлэхээр үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн үндсэн зарчмын дагуу хүүхэд бүр аюулгүй тайван, хүчирхийлэлгүй орчинд амьдрах эрхийг хангах механизмыг бүрдүүлэх зорилго бүхий цогц бодлогын хүрээнд

- Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулах,
- Хүүхдийн санаа бодлыг сонсох,
- Тэдний дуу хоолойг шийдвэр гаргах түвшинд хүргэх,
- Хүүхдийг хөгжүүлэх,
- Хүүхдийн оролцоог хангахад чиглэсэн үйлчилгээний нэгдэл бий болгох үндсэн зорилготой байгуулагдсан байна

Монгол улсад үндэсний хэмжээнд нэг утас ажиллах ба Хүүхдийн тусламжийн утас нь 24 цагийн турш үнэ төлбөргүйгээр Монгол улсын өнцөг булан бүрээс 0-18 насны хүүхдийн хамгаалал, хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчлийн тухай мэдээлэл хүлээн авч, тухайн орон нутаг, байгууллагын мэргэжлийн үйлчилгээнд холбон зуучлах, яаралтай тусламжийн үйлчилгээ үзүүлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх үйлчилгээнд холбон зуучлах, нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, хүүхдийн эрхийг хангахад чиглэсэн мэдээллийг хүргэх, хүүхдийн дуу хоолойг сонсон хүүхэд хамгааллын асуудлаар шийдвэр гаргахад болон хүүхэд хамгаалалд хүүхдийн оролцоог хангах, оролцоонд тулгуурлан хүүхдийг хөгжүүлэх, эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгаалалд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилготойгоор үйл ажиллагаагаа явуулж байна.

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2019-2023 онд Хүүхдийн тусламжийн дуудлагын 108 утсанд ирсэн дуудлагын тоог графикаар харуулбал дараах байдалтай байна.

Хүүхдийн 108 утасны дуудлагын мэдээлэл:


График №-9



2023 дуудлагын тоо өссөн ба өмнөх оноос 8.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Дуудлагын шийдвэрлэлтийн байдал

График № 10.



2023 оны байдлаар 259 дуудлагыг бүрэн шийдвэрлэсэн, 34 дуудлагыг харьяа хамтарсан баг хяналтад авч, шийдвэрлэх шатанд байна. Нийт дуудлагын шийдвэрлэлт 88.7 хувь. 2023 онд дуудлагын шийдвэрлэлтийн хувь өмнөх оноос 18.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

2024 оны хагас жилийн байдлаар 138 дуудлага, мэдээлэл хүлээн авч, шийдвэрлэлт 29 хувьтай байна. Нийт ирсэн дуудлага мэдээллийг ангилбал хүүхэд хамгааллын дуудлага 94.2 хувь, зөвлөгөө мэдээлэл хүссэн дуудлага 2.9 хувь, өргөдөл, гомдол 2.9 хувь тус тус эзэлж байна.

Нийт ирсэн дуудлагаас үнэлгээ хийгдсэн 38 буюу 27.5 хувь, үйлчилгээ үзүүлсэн 34 буюу 24.6 хувь, хаасан 40 буюу 29.0 хувь, ажиллаж дууссан 13 буюу 9.4 хувь, хяналтад 84 буюу 60.9 хувь, шилжүүлсэн дуудлага 14 буюу 10.1 хувийг эзэлж байна. Ирсэн дуудлага, мэдээллийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал 22 дуудлага буюу 13.8 хувиар буурсан байна.

3.3.3. Хөвсгөл аймгийн хэмжээнд хүүхэд хамгааллын чиглэлээр 7 төрлийн үйлчилгээг үзүүлж байгаа бөгөөд 2019-2023 онд нийт 4,067 тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Тусламж үйлчилгээний тоон мэдээллийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Тусламж үйлчилгээний тоон мэдээлэл

Хүснэгт №19.

Үйлчилгээ	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	Нийт
Аюулгүй байдлын хамгаалалт	34	125	132	158	155	570
Сэтгэл зүйн үйлчилгээ	170	364	331	128	27	850
Эрх зүйн үйлчилгээ	93	407	396	252	149	1,204
Эрүүл мэндийн үйлчилгээ	93	155	142	44	41	382
Нийгмийн халамжийн үйлчилгээ	55	68	32	32	43	175
Хүүхэд хамгааллын үйлчилгээ	9	163	136	176	195	670

Холбон зуучлах үйлчилгээ	53	92	41	30	53	216
Нийт үйлчилгээ	507	1,374	1,210	820	663	4,067

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний тоо жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байгаа бөгөөд эрсдэлд өртсөн хүүхдүүдэд нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийж хариу арга хэмжээг авч ажиллаж байна. Гэвч түр хамгаалах байр байхгүйгээс хүүхдийг 72 цаг нэг цэгийн үйлчилгээнд хамруулж дараа нь ар гэрт нь нэгтгэх ажлыг зохион байгуулж байна.

Эрсдэлт нөхцөлд орсон хүүхдүүдэд үзүүлсэн хариу арга хэмжээг үзүүлэхэд дараах хүндрэлтэй асуудлууд байна. **Үүнд:**

- Аймгийн хэмжээнд сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхдүүдэд сэтгэл заслын үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн боловсон хүчин байхгүй байна.
- Хөвсгөл аймгийн хэмжээнд түр хамгаалах байр байхгүйгээс зарим хүүхдүүдэд удаан хугацааны хамгаалал, нөхөн сэргээх үйл ажиллагаа хэрэгцээ, шаардлагатай байхад аюулгүй байдлыг бүрэн хамгаалж чадахгүй нөхцөл байдалтай байна.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад эрсдэлт байдлыг арилгах үйлчилгээ байхгүйгээс хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үед нөхцөл байдал хэвээр байгаа нь нөхөн сэргээх хариу үйлчилгээний үр дүнг сааруулж, хүүхдийг дахин хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.

3.3.4. Хөвсгөл аймгийн хэмжээнд гэмт хэргийн хохирогч болсон болон гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна.

Хүүхэд холбогдсон гэмт хэргийн тоо, мэдээ

Хүснэгт №20


Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 оны хагас жил
Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн тоо	15	8	7	31	39	12
Гэмт хэргийн хохирогч хүүхдийн тоо	7	37	21	57	62	10
Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүүхэд	5	8	11	11	8	6
Өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлсэн хүүхдийн тоо	4	8	14	7	9	5
Эрсдэлтэй хүүхдийн тоо	300	600	419	824	1,523	1,600

Хүснэгтийн тоон үзүүлэлтээс харахад сургалтын үйл ажиллагаа тасалдсан нь хүүхэд гэмт хэрэгт ихээр холбогдох, өртөх 1 шалтгаан гэж үзэж болохоор байна. Хөвсгөл аймгийн Цагдаагийн газрын хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтэн албан хаагчидтай уулзаж ярилцахад гэмт хэрэгт холбогдож байгаа, өртөж байгаа хүүхдүүдийн ихэнх нь эцэг, эх, асран хамгаалагч нь тухайн хүүхдийг анхаардаггүй, халамж, хяналт дутмаг гэр бүлийн хүүхдүүд байна.

Хөвсгөл аймгийн Цагдаагийн газраас хүүхдийг гэмт хэрэгт холбогдохоор урьдчилан сэргийлэх, хууль, эрх зүйн мэдлэг олгох сургалтыг тогтмол хийж ирсэн байна. Дэлхий нийтээр хөл хорио тогтоосон 2020-2022 оны ковид, цар тахлын үед сургалтын үйл ажиллагаа тасалдсан байна.

Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газар нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 2019-2024 оны байдлаар гэмт хэрэг зөрчилд холбогдсон нийт 51 хүүхэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг авсан байна.

График № 11. Дуудлага мэдээллийн ангилал



Хүүхдийн тусламжийн 108 утсанд ирсэн дуудлагын зөрчил гаргаж байгаа субъектээр авч үзвэл аав, ээж, багш, эмээ гэх мэт гэр бүлийн хүмүүсийн тоон үзүүлэлт өндөр байна.

Урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг нийт массыг хамруулан зохион байгуулж ажилласан хэдий ч гэмт хэрэг зөрчлийг арилгахад чиглэсэн зорилтод Сургалтыг зохион байгуулах ажил хангалтгүй байна.

Гэр бүлийн орчин, нөхцөл, харилцаанаас шалтгаалан хүүхэд гэмт хэрэгт холбогдох тохиолдол их байгаа нь хүүхэд хамгааллын асуудлыг гэр бүл буюу хүүхдийн төрж, өсөж байгаа орчинд анхаарах хэрэгтэйг харуулж байна. Тэр тусмаа хүүхэд төрүүлэх гэж байгаа иргэнийг хүүхдээ хамгаалагдсан орчинд өсгөх чадамжтай эсэхийг үнэлж хүүхдээ харах, эцэг, эх байх эрхийг нь тогтоож өгдөг тогтолцоо хэрэгтэй байна. Хүүхэд төрүүлэх гэж байгаа иргэдийн баталгаат орлого, гэр орны нөхцөл, архины хамаарал, сэтгэцийн болон бусад эрүүл мэндийн үзүүлэлт зэргийг урьдчилан хянаж үнэлэх нь хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хүүхэд хамгааллын эхний арга хэмжээ болно гэж дүгнэж байна.

3.3.5 Хөвсгөл аймгийн хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын 2024 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны танилцуулгад туссан хүүхэд хамгаалалтай холбоотой салбарын мэдээллийг харуулбал дараах байдалтай. Үүнд:

График №12




График №13



Салбарын байгууллагуудаас Цагдаа болон эрүүл мэндийн байгууллага хүүхэд хамгаалалтай холбоотой асуудал тус бүрийг нарийн судалж дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авч ажиллаж байна.

Харин боловсрол болон Онцгой байдлын газарт тоо мэдээллийг нэгтгээгүйгээс үр дүн шинжилгээ хийх боломжгүй нөхцөл байдалтай байна.

Асуумж, судалгааны үр дүнгийн талаар:

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитын хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээний чанар хүртээмж болон хүүхэд хамгааллын орчны талаар сонголттой 14, нээлттэй 2, нийт 16 асуултын хүрээнд нийт 3,984 хүнээс асуумж, судалгаа авсан. Асуумжийн үр дүн дараах байдалтай байна. Үүнд:

- Таны оршин суугаа нутаг дэвсгэрт хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагын талаар та хэр сайн мэдэх вэ гэдэг асуултад Сайн болон Маш сайн мэднэ гэж 1,300 хүн буюу 32.6 хувь, Бага болон Огт мэдэхгүй гэж 2,684 хүн буюу 67.4 хувь.
- Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд ямар утсанд хандах вэ? Гэсэн асуултад Хүүхдийн тусламжийн 108 утсанд хандана гэж 3,693 хүн буюу 92.7 хувь.
- Та хүүхэд хамгааллын шуурхай тусламж, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх үйлчилгээний талаар мэдэх үү? Гэсэн асуултад Сайн болон Маш сайн мэднэ гэж 1,137 хүн буюу 28.5 хувь, Дунд болон Огт мэдэхгүй гэж 2,847 хүн буюу 71.5 хувь.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаарх мэдээлэл хангалттай авч чаддаг уу? Гэсэн асуултад Хангалттай сайн гэж 645 хүн буюу 16.2 хувь нь хариулсан бол Дунд гэж 1,393

хүн буюу 35.0 хувь, Бага зэрэг гэж 1,387 хүн буюу 34.7, хувь, Огт авдаггүй гэж 562 хүн буюу 14.1 хувь.

- Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлогыг та хэрхэн дүгнэх вэ? гэдэг асуултад Сайн болон Маш сайн мэднэ гэж 1,081 хүн буюу 27.1 хувь нь хариулсан бол Дунд болон Хангалтгүй гэж 2,903 хүн буюу 72.9 хувь.
- Хүүхэд хамгааллын үйл ажиллагааны үр дүнг та хэрхэн дүгнэж байна вэ гэдэг асуултад Сайн болон Маш сайн мэднэ гэж 1,136 хүн буюу 28.5 хувь, Дунд буюу Муу гэж 2,848 хүн буюу 72.9 хувь.
- Хүүхдийн тусламж үйлчилгээг шуурхай үзүүлж чадаж байна уу? гэдэг асуултад Сайн болон Маш сайн мэднэ гэж 1,209 хүн буюу 30.3 хувь нь хариулсан бол Дунд болон Муу гэж 2,775 хүн буюу 69.7 хувь.
- Таны бодлоор хүүхэд хамгааллын чиглэлээр урьдчилан сэргийлэх үйлчилгээ хангалттай ажиллаж байна уу? гэдэг асуултад Сайн гэж 621 хүн буюу 15.5 хувь, Дунд болон Муу гэж 2,377 хүн буюу 59.7 хувь, Мэдэхгүй гэж 986 хүн буюу 24.8 хувь.
- Хүүхэд хамгааллын үйлчилгээний талаар хаанаас мэдээлэл авдаг вэ? Гэсэн асуултад ихэнх хүмүүс Цахим орчноос гэж хариулсан байна.
- Монгол Улсад хүүхэд эрүүл, аюулгүй өсөх, хөгжих боломж бүрдсэн гэж бодож байна уу? Гэсэн асуултад Сайн болон Хангалттай сайн гэж 659 хүн буюу 16.5 хувь, Дунд зэрэг болон Муу гэж 3,325 хүн буюу 83.5 хувь нь тус тус хариулсан байна.
- Сайжруулах санал байна уу гэсэн нээлттэй асуултад архины хамаарлаас болж байгаа гэмт хэрэг зөрчлийн талаар үр дүнтэй арга хэмжээ зохион байгуулах, Сургууль дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулах, Эцэг эхэд гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагааг дээшлүүлэх, Хүүхэд хамгааллын талаар сургалт сурталчилгааг илүү олон давтамжтайгаар олон нийтэд хүргэх, мэдээлэх гэсэн саналууд ихээр гарсан байна.

Асуумж судалгааны үр дүнгээс харахад хүүхэд хамгааллын талаар хийж байгаа сургалт мэдээлэл, нөлөөллийн ажил нь олон нийтэд бүрэн хүрээгүй, хүүхэд хамгаалах нөхөн сэргээх хариу арга хэмжээний үр дүн хангалтгүй байна.

Аудитаар нийт 145,878.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 23,680.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг таслан зогсоох давтан гаргахгүй байх 122,145.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага өгч, алдаа зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 10 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хүүхэд хамгааллын талаар хэрэгжүүлж байгаа бодлого, хөтөлбөрүүд нь хүүхэд, эмэгтэйчүүд, гэр бүл гэх мэт нийгмийн бүх бүлэгт чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байгаагаас харахад улс, орон нутгийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилт арга хэмжээнүүд хоорондоо уялдаж нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах боломжийг бүрдүүлсэн байна.
2. Нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтаршил, гэр бүл, хүүхдийн тоо, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралт зэргийг үндэслэн сум, хороонд ажиллах хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтны орон тоог тогтоох шалгуур үзүүлэлт, аргачлалыг Засгийн газар батлаагүйгээс орон нутагт хүний нөөцийн хүртээмж дутмаг, харилцан уялдаатай ажиллах нөхцөл бүрдээгүй байна.
3. Төсвийг эрсдэлт нөхцөлд байгаа болон сумдад байгаа хүүхдийн тоонд үндэслэж хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөж, хуваарилаагүй, хүүхэд хамгааллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан нь хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг бууруулж чадахгүй байна.
4. Хүүхэд хамгааллын үйлчилгээг тодорхой хэмжээнд үзүүлж байгаа хэдий ч сум орон нутагт хүүхэд хамгаалах байргүй, нэг цэгийн үйлчилгээний байрны орчин нөхцөл стандартын шаардлагад нийцээгүй, хүүхдийн эсрэг хүчирхийллийг арилгахад чиглэсэн бодитой ажлыг хийгээгүй зэрэг нь хүүхэд хамгааллын үйлчилгээг цогцоор нь хэрэгжүүлэх боломж бүрдээгүйг харуулж байна.
5. Хүүхэд хамгааллын чиглэлээр хэрэгжиж байгаа хууль, журам, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичигт хяналт-үнэлгээ хийх аргачлал батлагдаагүйгээс хяналтын тогтолцоо алдагдсан, үр дүнг тооцох боломжгүй байна.
6. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн гэр бүл, асран хамгаалагчдад эрсдэлт байдлыг арилгах үйлчилгээ байхгүйгээс хүүхдийг гэр бүлд нь эргэн нэгтгэх үед нөхцөл байдал хэвээр байгаа нь нөхөн сэргээх хариу үйлчилгээний үр дүнг сааруулж, хүүхдийг дахин хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна.
7. Хүүхэд хамгааллын нэгдсэн мэдээллийн системийг хүүхэд хамгааллын бүх түвшний үйлчилгээ үзүүлэгч бүрд нээлттэй байлгах, бусад салбарын мэдээллийн системтэй мэдээлэл солилцох байдлаар ашиглах, бүртгэлтэй мэдээлэлд дүн шинжилгээ хийн ажиллах нь хүүхдийг бүх орчинд хамгаалахад нэг чухал алхам болохоор байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжүүдийг өгч байна.

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, Засаг дарга-д

1. Хөвсгөл аймгийн хэмжээнд Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллах
2. Салбар бүр дэх хүүхэд хамгаалалтай холбоотой асуудал, тоон мэдээнд дүн шинжилгээ хийж түүний дагуу ажлаа төлөвлөж, гүйцэтгэл, үр дүнг аймгийн ИТХ-д жил бүрийн 3 дугаар улиралд багтаан тайлагнаж байх

Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга: Ч.Дашбаяр-т

3. Төсвийг эрсдэлт нөхцөлд байгаа болон сумдад байгаа хүүхдийн тоонд үндэслэж хүүхэд хамгаалах, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төлөвлөж, хуваарилах
4. Нэг цэгийн үйлчилгээний байрны орчин нөхцөлийг сайжруулж хүүхэд тухтай орчинд хамгаалагдах нөхцөлийг бүрдүүлэх
5. Хамтарсан багийн үйл ажиллагааг жигдрүүлэх, баримт бичгийн нууцлал, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах.

Боловсрол шинжлэх ухааны газрын дарга: О.Бадраа-д

6. Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны хүчин чадал, орчин нөхцөлийг сайжруулах, стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
7. "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам" болон "Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлого"-ын хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг тооцож ажиллах.
8. Хүүхэд хамгааллын чиглэлээр боловсролын салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөр арга хэмжээнүүдийн хэрэгжилт, үр дүг тооцон үнэлж байх.

Биеийн тамир спортын газрын дарга Б.Очирбат, Соёлын газрын дарга Л.Батцэцэг нарт.

9. Хөвсгөл аймгийн хэмжээнд "Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" журмыг мөрдөж соёл, спортын үйл ажиллагаанд хүүхдийн аюулгүй байдлыг хангаж ажиллах.

Хөвсгөл аймгийн онцгой байдлын газрын даргад

10. Гамшгийн үеийн онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар сургалт, сурталчилгааг хийж гамшгийн эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийн судалгаа, мэдээллийг нэгтгэж нэгдсэн мэдээллийн сан үүсгэх.

Зөрчлийн жагсаалт

№	Аудитаар илэрсэн		Өгсөн албан шаардлага		Тавьсан акт		Зөвлөмж	
	Зөрчлийн утга	Зөрчлийн дүн /сая төг/	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Хамтарсан багуудын үйл ажиллагаа тогтмолжоогүй, үр дүнтэй ажил зохион байгуулаагүй						1	
2	Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Шүүх, прокурорын байгууллагын хүүхдийн асуудал хариуцсан ажилтан, алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх ажлыг зохион байгуулаагүй							
3	Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд "Хүүхдийн эрхийн тухай хууль болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтэд гурван жил тутамд анхан шатны хяналт шинжилгээ, үнэлгээ хийгээгүй							
4	ХГБХХГ-ын бүтэц орон тоогоор хүүхдийн хөгжил хамгаалал хариуцсан 2 мэргэжилтэн ажиллахаар батлагдсан хэдий ч хариуцсан ажилтан байхгүй орон тоо нь сул учраас хүүхэд хамгааллын ажлыг үр дүнтэй, хэрэгжүүлэх хүний нөөц бүрдээгүй.							
5	Хүүхэд хамгааллын зардлыг төлөвлөхдөө бодит тооцоо судалгаанд үндэслэн тооцож төлөвлөөгүй, урьдчилан сэргийлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдээр хийгдэх хөтөлбөр арга хэмжээ, үйл ажиллагаануудыг ангилан ялгахгүй төлөвлөж батлуулсан.							
6	Хүүхэд хамгааллын зардал хаана батлагддаг ямар зардал байдаг талаар ойлголтгүй байгаа нь ХГБХХ-ын газар нь үйл ажиллагаа, төсөв санхүүгийн мэдээллийг иргэд олон нийт болон хамтарсан багийн гишүүдэд мэдээлээгүй						1	
7	ХГБХХ-ын газар нь 2022 онд Хөвсгөл дулааны станц ТӨХК-д Хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 8,000,000 төгрөгийг байгууллагын халаалт дулааны төлбөрт шилжүүлсэн	8.0		8.0				
8	Хамгаалах нөхөн сэргээх зардлаас Уралдаанч хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах зардал гэж нэг хүүхдэд 14,000 төгрөгөөр тооцон нийт 4,616,500 төгрөгийн ариун цэврийн болон бага үнэтэй түргэн элэгдэх материалыг олгосон	4.6	1	4.6				
9	Хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас сургалт зөвлөгөөн, арга хэмжээ зохион байгуулж хоолны зардалд 2022 онд 16,215,000 төгрөг, 2023 онд 12,787,000 төгрөгийг нийт 29,002,000 төгрөгийг зарцуулсан	29.0		29.0				
10	Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 2022 онд 6,393,000 төгрөг, 2023 онд 15,103,000 төгрөг нийт 21,496,000 төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг хүүхдүүдэд тараасан	21.5		21.5				

11	Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний дэмжлэгийн зардал гэж 2022 онд 16,744,000 төгрөг, 2023 онд 10,920,000 төгрөг нийт 27,664,000 төгрөгийн ариун цэврийн хэрэгсэл, ундаа, печенийн зардалд зарцуулсан байна. Гэвч эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийн ар гэрт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулах арга хэмжээнд зориулж нэг удаагийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан	27.7	27.7				
12	Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээнд 8,941,900 төгрөгийг зарцуулснаас 5,246,000 төгрөгийг хоол, үдийн цайны зардалд, үзүүлэх тоглолтын зардалд 1,000,000 төгрөгийг тус тус зарцуулсан	6.2	6.2				
13	Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх тухай ХГБХХГ-ын даргын 2023 оны А/200 дугаар тушаалаар нийт 25,174.0 мянган төгрөгийн багцыг олгосон хэдий ч сумдад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийгээгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоо мэдээлэл, судалгаа тодорхой болсон байхад 2023 онд шинээр эрсдэлийн үнэлгээ хийж илрүүлж байгаа мэтээр тайлагнаж хүүхдүүдэд багц тарааж үр ашиггүй зардал гаргасан	25.2	25.2				
14	Хүүхдийн чуулганыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдөр холбогдох байгууллагуудад нийт 23,680.0 мянган төгрөгийн зардлыг шилжүүлсэн боловч одоог хүртэл зохион байгуулаагүй бөгөөд авлага үүсгээгүй, хоорондын тооцоогоор баталгаажуулаагүй	23.7		1	23.7		
15	Хамтарсан багуудын үйл ажиллагаанд хяналт хийхэд хувь хүний нууцыг хадгалах орчин нөхцөл бүрдээгүй ХГБХХ-ын газраас заавар зөвлөмж өгч холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. Тухайлбал: Хамтарсан багийн гишүүдтэй нууцын гэрээ байгуулаагүй, Нууцын баталгаа гаргуулаагүй, баримт бичиг хадгалах тусгай сейф байхгүй баримт материал кейсүүд нь албан хаагчийн 10ширээн дээр байрлаж байгаа нь хувь хүний нууц алдагдах эрсдэлтэй байна					1	
16	Эцэг, эх, асран хамгаалагчдад хүүхдийг сөрөг мэдээллээс хамгаалах мэдлэггүй мэдээлэл дутмаг байна. Мөн бүтэн өнчин болон ядуу өрхийн хүүхдэд тусламж үзүүлж буй байгууллага, хувь хүмүүс нь тухайн хүүхдийн зураг болон бусад мэдээллийг олон нийтийн сүлжээнд оруулж байгаад хяналт хэрэгжүүлээгүй						
17	Хөвсгөл аймгийн хэмжээнд Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга, Соёл урлагийн газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А/242, А/76 дугаар хамтарсан тушаалаар					1	

	"Соёл, спорт, олон нийтийн үйл ажиллагаанд хүүхдийг оролцуулах, эрхийг хамгаалах" журмыг мөрдөж ажиллахгүй						
18	Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүргээ 2019, 2020, 2021, 2022, 2023 онуудад хэрэгжүүлээгүй					1	
19	Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхэд хамгааллын талаар 2019-2023 онуудад хийсэн ажлын тайланг хэлэлцэж дүгнэлт гаргаж үр дүнг олон нийтэд мэдээлээгүй, Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулаагүй.					1	
20	Хүүхдийн төлөө зөвлөл нь Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад хүүхэд хамгааллын бодлогын ажлыг таниулах, эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг чадавхжуулах ажлыг 2018 оноос хэрэгжүүлж байгаа боловч гэр бүлийн орчинд нөлөөлж буй нөлөөллийн талаарх үнэлгээ хийгээгүй, үр дүнг тооцоогүй					1	
21	Хүүхдүүдэд зориулсан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, аюул тохиолдсон үед амь нас, эрүүл мэндээ хамгаалах талаар сургалтыг зохион байгуулж, олон нийтэд сурталчилж байгаа боловч онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хэрхэн хамгаалах талаар сургалт, сурталчилгааг хийхгүй байна. Гамшгийн эрсдэлтэй нөхцөл байдалд байгаа хүүхдүүдийн судалгаа, мэдээллийг нэгтгээгүй					1	
22	Хөвсгөл аймгийн хэмжээнд БШУ-ны сайдын 2022 оны А/453 дугаар тушаалаар баталсан "Ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны орчинд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам", Боловсрол шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/269 дүгээр тушаалаар баталсан Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт тус тус хангалтгүй					1	
23	Хүүхэд хамгаалал, болон бусад олон салбарын байгууллагаас чиглэлээр ЕБС-иудад олон сургалт, аяныг зохион байгуулж байгаа боловч талбар дээр гардаж ажиллахгүй, тухайн сургуулиас тайлан гаргуулж авах түвшинд үр дүн хангалтгүй					1	
24	Ерөнхий боловсролын сургуулиудын дотуур байрны хүчин чадал хүрэлцээгүй, орчин нөхцөл стандартын шаардлагад бүрэн нийцээгүй					1	
Дүн		145.9	1	122.2	1	23.7	10

Холбогдох байгууллагын санал тайлбар.

Байгууллагаас ирсэн санал тайлбар.	Хариу тайлбар
ХӨВСГӨЛ АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР Багшийн хөгжлийн ордон, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 3693, Цахим шуудан: khuvs gul@mecs.gov.mn 2024.10.25 № 726 танай _____-ны № _____-т ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ Тайлангийн төсөл дээр санал тайлбар байхгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах болно. ДАРГА  О.БАДРАА	Санал тайлбар ирүүлээгүй

МОНГОЛ УЛС ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА АЗДТГ-ын байр, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120 Утас: 7038 2300, 7038 3303, факс: 7038 1001 Цахим шуудан: huvsgulzdtg@khs.gov.mn Цахим хуудас: www.khovsgol.gov.mn АВАЧ. 10. 05 № 2/1893 танай _____-ны № _____-т ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Нэмэлт тайлбар байхгүй. Хүүхдийн төлөө орон нутгийн зөвлөлийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг үр дүнтэй хангах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллана. ОРЛОГЧ  М.ХУЯГБААТАР My Doc/ jijig toot 6712071629	Санал тайлбар ирүүлээгүй
---	--



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ХҮҮХЭД, ГЭР БҮЛИЙН ХӨГЖИЛ,
ХАМГААЛЛЫН ГАЗАР**

7 дугаар баг, Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120.

Утас: 70382105

Цахим шуудан: hgbhgg@khs.gov.mn, khuvsgul@crga.gov.mn

2024.10.25 № 415

танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ТАНАА

“Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого, түүний хэрэгжилт, үр дүн”-д хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Нэмэлт тайлбар байхгүй. Харин хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын салбарын байгууллагуудын мэргэжилтэн, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар тусгайлсан бодлого, хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх нь зүйтэйг санал, дүгнэлт хэсэгтээ тусгаж өгөхийг хүсье.

ДАРГА

Ч.ДАШБАЯР



671203386

Санал тайланд
тусгагдсан болно.



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 10 сарын 25 өдөр

№ 93/АА.250439/ХАА-2024/20-21
МТН - ТН

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн “Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын төсвөөс Хөвсгөл аймгийн Хүүхдийн чуулганыг 2023 оны 12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн 2023 оны 12 дугаар сарын 18-аас 19-ны өдөр холбогдох байгууллагуудад нийт 23,680,000 /хорин гурван сая зургаан зуун наян мянга/ төгрөгийн зардлыг шилжүүлсэн боловч одоог хүртэл зохион байгуулаагүй бөгөөд авлага үүсгээгүй, хоорондын тооцоогоор баталгаажуулаагүй байна.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; 16 дугаар зүйлийн 16.5.5 батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4.үнэн зөв байх; 13 дугаар зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно, 20 дугаар зүйлийн 20.1.4.хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэсэн заалтуудыг үндэслэн


ТОГТООХ нь:

- Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын төсвөөс гаргасан 23,680,000 /хорин гурван сая зургаан зуун наян мянга/ төгрөгийг харилцагч байгууллагаас Хөвсгөл аймгийн төрийн санд байрших Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын 100170014702 тоот /нэмэлт санхүүжилтийн/ дансанд татан төвлөрүүлэх;

6724020357

2. Төлбөрийн актын биелэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Ч.Дашбаяр, нягтлан бодогч О.Өлзийжаргал нарт даалгав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР:  Б.ДАВААНЯМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 10 сарын 25 өдөр

№ 95/А 2260439/ХАА-2024/ Мөрөн сум
20-21-#ТА-ГА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүүхэд хамгааллын талаар төрөөс баримталж буй бодлого түүний хэрэгжилт үр дүн” гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ.

Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар нь хүүхэд хамгаалах үйл ажиллагааны зардлаас 122,198,500 /нэг зуун хорин сая нэг зуун ерэн найман мянга таван зуу/ төгрөгийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулсан байна. Үүнд:

- Хүүхэд хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2022 онд Хөвсгөл дулааны станц ТӨХК-д 8,000,000 /найман сая/ төгрөгийг байгууллагын халаалт дулааны төлбөрт шилжүүлсэн.
- Аймгийн төвийн хурдан морины уралдаанч 330 хүүхдүүдэд нэг бүр нь 14.0 мянган төгрөгийн үнэ бүхий багцыг олгож, нийт 4,616,500 /дөрвөн сая зургаан зуун арван зургаан мянга таван зуу/ төгрөгийг зарцуулсан.
- Бүсийн чуулган, Уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах, Хүн ам зүйн чиг хандлага ба гэр бүл нэгдсэн арга хэмжээ, байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөгөөн зохион байгуулах зэрэг сургалт, арга хэмжээний хоолны зардалд 2022 онд 16,215,000 /16 зургаан сая хоёр зуун арван таван мянга/ төгрөг, 2023 онд 12,787,000 /12 хоёр сая долоон зуун наян долоон мянга/ төгрөгийг нийт 29,002,000 /хорин есөн сая хоёр мянга/ төгрөгийг зарцуулсан.
- Хүүхдийн эрхийг хамгаалах өдрөөр 2022 онд 6,393,000 /зургаан сая гурван зуун ерэн гурван мянга/ төгрөг, 2023 онд 15,103,000 /арван таван сая нэг зуун гурван мянга/ төгрөг нийт 21,496,000 /хорин нэгэн сая дөрвөн зуун ерэн зургаан мянга/ төгрөгийн бэлэг дурсгалын зүйлийг хүүхдүүдэд тараасан.
- Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээний дэмжлэгийн зардалд 2022 онд 16,744,000 /арван зургаан сая долоон зуун дөчин дөрвөн мянга/ төгрөг, 2023 онд 10,920,000 /арван сая есөн зуун хорин мянга/ төгрөг нийт 27,664,000 /хорин долоон сая зургаан зуун жаран дөрвөн мянга/ төгрөгийн ариун цэврийн хэрэгсэл, ундаа, печенийн зардалд зарцуулсан байна. Гэвч эрсдэлтэй нөхцөлд байгаа хүүхдүүдийн ар гэрт очиж нөхцөл байдлын үнэлгээ хийгээгүй боловч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдтэй уулзалт зохион байгуулах арга хэмжээнд зориулж нэг удаагийн дэмжлэг үзүүлэхэд зарцуулсан.
- Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн зөвлөгөөн зохион байгуулах арга хэмжээд 8,941,900 /найман сая есөн зуун дөчин нэгэн мянга есөн зуу/ төгрөгийг зарцуулснаас 5,246,000 /таван сая хоёр зуун дөчин зургаан мянга/ төгрөгийг хоол, үдийн цайны зардалд, үзүүлэх тоглолтын зардалд 1,000,000 /нэг сая/ төгрөг нийт 6,246,000 /зургаан сая хоёр зуун дөчин зургаан мянга/ төгрөгийг зарцуулсан.
- Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх тухай Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газрын даргын 2023 оны А/200 дугаар

6724030363

тушаалаар нийт 25,174,000 /хорин таван сая нэг зуун далан дөрвөн мянга/ төгрөгийн багцыг олгосон хэдий ч сумдад эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн эрсдэлийн үнэлгээг хийгээгүй, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдүүдийн тоо мэдээлэл, судалгаа тодорхой болсон байхад 2023 онд шинээр эрсдэлийн үнэлгээ хийж илрүүлж байгаа мэтээр тайлагнаж хүүхдүүдэд нэг удаагийн шинжтэй багц тараасан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4.төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх; 16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3.үр ашигтай байх, 15 дугаар зүйлийн 15.1.5.төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахгүй байх гэсэн заалтууд болон Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2022 оны А23/27 дугаар тушаалаар баталсан Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний нормативтай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.6.төсвийг зориулалт бусаар зарцуулсан гэсэн заалтуудыг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулж, төсвийн үр ашгийг бууруулсан зөрчлийг таслан зогсоож, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, төсвийн сахилга батыг сайжруулан ажиллах .
2. Албан шаардлагын биелэлтийг 2025 оны 05 дугаар сарын 01-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт¹ нотлох баримтын хамт ирүүлэхийг Хөвсгөл аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга Ч.Дашбаяр, нягтлан бодогч О.Өлзийжаргал нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АХЛАХ АУДИТОР:

Б.ДАВААНЫМ

¹ Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

Хавсралт №1

Суманд ажиллаж буй нийгмийн бодлогын мэргэжилтнүүдийг мэргэжлийн мэргэжлийн индексийг харуулбал дараах байдалтай байна.

Боловсрол /011, Эрүүл мэндийн, нийгмийн хамгаалал /09/, Хүмүүнлэг /022/, социологи, соёл судлал /0314/, төрийн удирдлага /041303/, гэр бүл судлал мэргэжилтэй хүмүүс ажиллаж болохоор заасан байна.

№	Сум	Мэргэжил	Мэргэжилийн индекс
1	Араг-Эрдэнэ	Төрийн удирдлага	0 41303
2	Арбулаг	Төрийн удирдлага	0 41306
3	Баянзүрх	Эрх зүйч	0 421
4	Бүрэнтогтох	бизнесийн удирдлага -ня-бо	0 411
5	Галт	Нийгмийн ажилтан	0 92
6	Жаргалант	Нийгмийн ажилтан	0 92
7	Их-Уул	Эрх зүйч	0 421
8	Рашаант	Төрийн удирдлага менежер, Ня-бо	0 41306
9	Ренчинлхүмбэ	Төрийн удирдлага	0 41306
10	Тариалан	Нийгмийн ажилтан	0 92
11	Тосонцэнгэл	Эрх зүйч	0 421
12	Төмөрбулаг	Нийгэм судлал-Эрхзүйн багш	0 11
13	Түнэл	Нийгмийн ажилтан	0 92
14	Улаан-Уул	Эрх зүйч	0 421
15	Ханх	Компьютер англи хэлний Багш	0 11
16	Хатгал	Эрх зүйч	0 421
17	Цагааннуур	Түүх, нийгмийн ухааны багш	0 11
18	Цагаан-Үүр	Эдийн засагч, нийгмийн ажилтны удирдлага төрийн захиргаа	0 41306
19	Цагаан-Уул	Нийгмийн ажилтан	0 92
20	Цэцэрлэг	Түүх, нийгмийн ухааны багш	0 11
21	Чандмань-Өндөр	Менежмент төрийн захиргааны удирдлага	0 41306
22	Шинэ-Идэр	Эрх зүйч	0 421
23	Эрдэнэбулган	Төрийн удирдлага, архивч	0 41306
24	Мөрөн	Багш	0 11